# ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДАВААСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. "Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах" | | | | | | | |
| 1. | Бараа, тээврийн хэрэгсэл, чингэлэг, манифестын хяналтыг сайжруулах. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Манифестын хяналтыг сайжруулна.<br>-Бараа, тээврийн хэрэгслийн гаалийн хяналтад бүрэн хамруулна.<br>-Гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлнэ. | 1.Хилээр оруулах, дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авахдаа ачааны манифестыг үндэслэж байна. Гаалийн шинэчлэлийн хүрээнд CAIS-т нэмэлт, өөрчлөлтүүд оруулж, шинээр тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмыг нэвтрүүлсэн боловч гаалийн бүрдүүлэлт хийгдсэн, үлдэгдэлгүй манифест CAIS-т хаагдахгүй алдаатай байгаа учраас хаагдаагүй манифестын тоог нэмэгдүүлж байна. Дээрх алдааг засварлуулах саналаа МТГ-т хүргүүлсэн. CAIS-ын манифестын програм дахь 2,259.822 үлдэгдлийн жагсаалтыг гаргаж, гаалийн газар, хороодын дарга нарт 2024.04.19-ний өдөр 02-1/1540, 2024.11.04-ний өдрийн 02-1/4557 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлж, нягтлан шалгуулсан. Үүний үр дүнд 1,623.292 манифест буюу 28.1 хувийг нь гаалийн газар, хороод нягтлан шалгаж, зохих төлөвт оруулсан.<br>-2023 онд хугацаандаа хаагдаагүй импортын 19,303 манифест байсан бол 2024 онд 16,875 болж 12.5% буурсан.<br>-2023 онд хугацаандаа хаагдаагүй экспортын 1,924.707 манифест байсан бол 2024 онд 615,908 болж 67.9 % буурсан.<br>-2023 онд хугацаандаа хаагдаагүй дотоодын 11,783 манифест байсан бол 2024 онд 3,747 болж 68.1 % буурсан.<br>2.Улсын хилээр бараа, зорчигч тээвэрлэн, эсхүл хоосон нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүртгэн, гаалийн хяналтад авч, гаалийн шалгалт хийж байна. Хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн тээврийн хэрэгслийн хяналтыг сайжруулах зорилгоор гаалийн газар, хороодод 2024.07.05-ны өдрийн 02-1/2761 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлж, хяналт тавьж ажилласны үр дүнд 2023 онд хилээр хугацаандаа буцаж нэвтрээгүй 11275 тээврийн хэрэгсэл байсан бол 2024 онд дээрх тээврийн хэрэгслийн тоо 8608 болж 23.6 % буурсан байна.<br>3.Гаалийн хяналт, шалгалтыг сайжруулж, оновчтой зохион байгуулж, гаалийн хууль тогтоомжийн зөрчил илрүүлэлтийг нэмэгдүүлж, улсын хилээр нэвтрэх бараа, тээврийн хэрэгслийг | 01.02<br>12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хяналтад бүрэн хамруулах зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулсан.<br>1.Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах тухай АТГ-аас 2024 оны 3, 4, 5, 8, 9, 12 дугаар саруудад ирүүлсэн 72/73, 27, 39, 49, 32, 123, 187 дугаартай мөрдөгчийн мэдэгдлүүдийг үндэслэн гаалийн газар, хороодод хяналтаа сайжруулах тухай нийт 24 чиглэлийг 02-1/1541, 1542, 1637, 1748, 3379, 3588, 3657, 5009 дугаартай 8 удаагийн албан бичгээр хүргүүлсэн. Дээрх чиглэлийн хариуг ирүүлсэн 45 албан бичгийг хүлээн авч хянаж, танилцаад нэгтгэсэн дүгнэлтээ 2024.05.31-ний өдрийн 02-1/2152 дугаартай албан бичгээр хүргүүлж, анхааруулсан.<br>Хүрсэн түвшин:<br>1.Хугацаандаа хаагдаагүй импортын манифест 16,875 болж 12.5% буурсан.<br>2.Хугацаандаа хаагдаагүй экспортын манифест 615,908 болж 67.9 % буурсан.<br>3.Хугацаандаа хаагдаагүй дотоодын манифест 3,747 болж 68.1 % буурсан.<br>4.Улсын хилээр бараа, зорчигч тээвэрлэн, эсхүл хоосон нэвтрээд хугацаандаа хаагдаагүй тээврийн хэрэгслийн тоо 8608 болж 23.6 % буурсан байна.<br>5.2023.01.01-ний өдрөөс 2023.10.31-ний өдрийн байдлаар 9194 Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас Маягт №2 бичиж, нийт 1,080,981,378.00 төгрөгийн гаалийн болон бусад татвар ногдуулсан байсан. Харин 2024.01.01-ний өдрөөс 2024.10.31-ний өдрийн байдлаар 18985 Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас /Маягт №2/ бичиж, нийт 1,929,117,988.00 төгрөгийн гаалийн болон бусад татвар ногдуулсаныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас Маягт №2-ын тоо 2 дахин, татварын үнийн дүн 78 хувиар тус тус өссөн.<br>6. АТГ-аас 2024 оны 3, 4, 5, 8, 9, 12 дугаар саруудад ирүүлсэн 72/73, 27, 39, 49, 32, 123, 187 дугаартай мөрдөгчийн мэдэгдлүүдийг үндэслэн гаалийн газар, хороодод хяналтаа сайжруулах тухай нийт 24 чиглэлийг 02-1/1541, 1542, 1637, 1748, 3379, 3588, 3657, 5009 дугаартай 8 удаагийн албан бичгээр хүргүүлсэн. АТГ-т мөрдөгчийн мэдэгдлийн хариуг тухай бүр хугацаанд нь хүргүүлсэн. | | |
| 2. | Гаалийн баталгаат бүс, чөлөөт бүс, гаалийн хяналтын | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журмын хэрэгжилтийг сайжруулна. | 1.МУ-ын ДШЗХТ-ын 2023.12.25-ны өдрийн 02-р тогтоолын дагуу ГЕГ-ын даргын 2019 оны А/282 дугаартай тушаалаар батлагдсан “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах ГЕГ-ын даргын 2024 оны А/338 дугаар тушаалыг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. | 01.02<br>12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүсийн хяналтыг сайжруулах. | | | -license.mn-ээр ирүүлсэн хүсэлтийн хяналтыг сайжруулж, ГТСМТТ УҮГ-тай хамтран ажиллана.<br>-Гаалийн хяналтын бүсэд орох, гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг ухаалаг гарцын тоног төхөөрөмжөөр бүртгэж, хяналт сайжруулах чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Дээрх тушаалаар ГЕГ-ын даргын 2019 оны А/223 дугаар тушаалаар батлагдсан Зорчигчийн журмын 2.3.1-д заасан барааг чөлөөт бүсэд зорчигчдийн худалдан авалтын давтамжийг бууруулж, татвараас зайлсхийх нөхцөл байдал үүсгэхгүй болгох зорилготой зохицуулалтыг тусгасан.<br>2.lisence.mn-ээр ААН-ээс ирүүлсэн хүсэлтийг хянаж, шийдвэрлэх,хяналтыг сайжруулах зорилгоор СМТТ УТҮГ-т дараах 5 саналыг хүргүүлж, 2 саналыг шийдвэрлүүлсэн:<br>- ГХБ-ээр тогтоолгосон талбай нь тухайн талбайд олгосон ААН-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээний Y дугаартай холбогдсон байдаг. Гэтэл тухайн гаалийн хяналтын бүсэд байрлалтай түр агуулах, гаалийн баталгаат агуулахад холбох Y дугаар нь дээрх дугаартай давхацсан байгааг тусад нь хүлээн авах асуудлыг шийдвэрлүүлсэн.<br>-цахим системд шилжүүлэхээс өмнө зөвшөөрөл авсан ААН-ийн мэдээллийг нөхөж оруулах.<br>Дараах чиглэлээр хүргүүлсэн саналыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.<br>-Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн гаалийн байгууллагаас олгосон гэрчилгээг системээс автоматаар олгох;<br>-татварын улсын байцаагчийн нөхөн ногдуулалтын акт, татварыг хэсэгчлэн төлөх хуваарьтай холбоотойгоор цахимд татварын өртэй гэсэн алдаатай тайлбар гарч байгааг шалгуулах.<br>3.“Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах журам”-ын төслийг боловсруулж Захиргааны ерөнхий хуулийн 62-т заасны дагуу customs.gov.mn-д 2024.06.10-ны өдөр байршуулж олон нийтээс санал авсан. Төслийг танилцуулж, санал авах зорилгоор СЯ, ГХЯ, ИНЕГ, NUBA ХХК, гаалийн газар, хороодын дарга нарт 2024.06.07-ны өдрийн 02/2319- 02/2323 дугаартай албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн. ГЕГ-ын ЗББНДБ-д 2024.06.07-ны өдрийн 225 дугаартай дотоод зурвасаар хүргүүлж, CERP-д байршуулсан. ГЕГ-ын удирдлагаас өгсөн үүргийн дагуу СЯ-аас ирүүлэх саналыг хүлээж байна.<br>4.ГХБ-д оруулж, гаргаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэх RFID суурилуулж, бодит цагийн горимд СМТТ УТҮГ-ын smartgate.ecustoms.mn системд холбуулах даалгаврыг 2024.02.28-ны өдрийн 02-1/762 дугаартай албан бичгээр ГХБ эзэмшигч нарт хүргүүлсэн. Дээрх ажилтай холбогдуулан RFID болон системд тавигдах шаардлагыг gaali.mn -ын “Гарын авлага, заавар” хэсэгт байршуулж, мэдээлэл өгсөн. RFID-г АБТЭМА, Монголтранс, Туушин ГХБ-д, Цагаанхад суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа 27 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ГХБ-д суурилуулсан, үйл ажиллагаа явуулахгүй байгаа 14 ГХБ-д суурилуулаагүй. Шивээхүрэн боомтоор нүүрс экспортлогч 6 компани уурхай дахь талбайд RFID-г бүрэн суурилуулсан. СМТТ УТҮГ-тай холбогдон програмын хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж байна.<br>Хүрсэн түвшин:<br>1.Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ГЕГ-ын даргын 2024 оны А/338 дугаар тушаалыг батлуулж, 5 удаа албан бичгээр чиглэл хүргүүлж ажилласны үр дүнд зорчигчийн журмын 2.3.1-д заасан барааг чөлөөт бүсэд зорчигч худалдан авах давтамжийг бууруулж, татвараас зайлсхийх оролдлогыг багасгасан.<br>2.CAIS-ийн чөлөөт бүсийн програмд зорчигчийн худалдан авалтын бүртгэлтэй холбоотой гарсан алдааг МТГ-ын албан хаагч нараар засуулсан;<br>3.ГББ-ийн горимд байршуулах хугацаа хэтэрсэн барааг шийдвэрлэх тухай 02-1/4025 албан бичгийг гаалийн ГХ-ны дарга нарт хүргүүлж, УБГГ, ГСГГ-ын хяналтад үйл ажиллагаа явуулдаг ГББ-д хадгалах хугацаа хэтэрсэн бараанд гаалийн бүрдүүлэлт хийлгэсэн.<br>4."Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах журам"-ын төслийг боловсруулж, ГЕГ-ын МЗХ-д танилцуулахад бэлтгэсэн. ГЕГ-ын удирдлагаас өгсөн үүргийн дагуу СЯ-аас ирүүлэх саналыг хүлээж байна.<br>5.Гаалийн газар, хороодод 3 албан бичгээр чиглэл хүргүүлж, smartgate.ecustoms.mn системд холбуулах болон RFID-д тавигдах шаардлагыг gaali.mn-д байршуулсанаар 36 ААН-д гаалийн хяналтын бүсдээ RFID суурилуулсан. Үүний үр дүнд ГХБ-д нэвтрэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтыг сайжруулна.<br>6.ГХБ, ГББ, ЧБ-д оруулсан ОАТ-тай барааны хяналтыг сайжруулах зорилгоор тусгай зөвшөөрөл, ОАТ-ын тэмдэгтэй холбоотой мэдээллийг ХХААХҮЯ, ТЕГ-тай солилцох системын хөгжүүлэлтийг хийлгэж байна. Үүний үр дүнд гадаад худалдаанд оролцогч нар согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын мэдүүлгийг цаасаар гаалийн байгууллагад гаргаж өгөх шаардлагагүй болж, бүрдүүлэх бичиг баримтын тоо багасна. | | |
| 3. | ГИТ-ийн хяналтыг сайжруулах. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | license.mn-ээр ирүүлсэн хүсэлтийг шалгаж, МЗХ-д танилцуулж шийдвэрлүүлнэ. | 1.ГЕГ-ын даргын 2022 оны А/338 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуур"-ыг үндэслэн аж ахуйн нэгжээс "тусгай зөвшөөрлийн цахим систем" буюу license.mof.gov.mn-ээр ирүүлсэн 199 хүсэлтийг хүлээн авч хянаж, ГЕГ-ын МЗХ-ны хуралдаанд | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | -ГИТ-ийн талаар танилцуулга бэлтгэж, удирдлагыг мэдээллээр хангана.<br>-ГТСМТТ УҮГ-тай license.mn-ийн хяналтыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллана. | 2024.01.22-ны өдөр 70, 2024.03.04-ний өдөр 27, 2024.05.13-ны өдөр 33, 2024.06.14-ний өдөр 23, 2024.09.19-ний өдөр 37, 2024.10.24-ний өдөр 9 буюу нийт 199 ААН-ийн асуудлыг МЗХ-д танилцуулж шийдвэрлүүлсэн. Мөн 2024 оны 12 дугаар сарын МЗХ-д 35 ААН-ийн хүсэлтийг танилцуулж, шийдвэрлүүлэхээр бэлтгэсэн.<br>ААН-ээс ирүүлсэн ГИТ-ийн хугацаа сунгуулах 37 ААН, чиглэл нэмүүлэх 67 ААН-ийн хүсэлтийг судалж, ГЕГ-ын даргын тушаалаар батлуулсан. Мөн ГИТ-ийн сунгуулах хүсэлт ирүүлсэн 4 ААН, чиглэл нэмүүлэх хүсэлт ирүүлсэн 18 ААН-ийн хүсэлтийг судалж, ГЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар ажиллаж байна.<br>2.ЗТ-ийн сайдаас 2024.05.21-ний өдрийн 01/2241 дугаартай албан бичгийн хавсралтаар СЯ-д хүргүүлсэн "Улс хооронд байнгын ачаа тээврийн зөвшөөрлийн бичиг олгох, тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих журам"-ыг батлах тухай ЗГ-ын тогтоолын төслийг 2024.06.07-ны өдөр хүлээн авч, танилцсан. МУ-ын ЗГ, БНХАУ-ын ЗГ хоорондын 2011 оны Автотээврийн хэлэлцээрийн 3.1-т заасны дагуу АТҮТ-өөс улирал 1 удаа олгосон С зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслээр БНХАУ-тай хиллэдэг боомтоор улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэдэг. ГТХ-ийн 2711 дүгээр зүйлийн 2711.1.16, ГЕГ-ын даргын 2022 оны А/338 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуур”-ын 2.1 дэх хэсгийг үндэслэн тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд 3 жил хүртэлх хугацаагаар гаалийн итгэмжлэл олгохдоо АТҮТ-өөс улирал тутам олгодог хил нэвтрэх С зөвшөөрөлтэй байх шаардлага тавьдаггүй. Иймд дээрх журмын төсөлд “2.3.7.Тээвэрлэгч байгууллагад гаалийн удирдах төв байгууллагаас олгодог итгэмжлэлтэй байх.” гэсэн заалт шинээр нэмж оруулах мөн бусад 12 санал танилцуулж, нэгтгэсэн саналыг 2024.06.07-ны өдрийн 02/2325 дугаартай албан бичгээр СЯ-ны ТНБД-д хүргүүлсэн.<br>-Гаалийн байгууллагаас ГИТ-д тавьж байгаа хяналт, эрх зүйн зохицуулалтай холбоотой PPT бэлтгэж, удирдлагад 2024 оны 1 дүгээр сард танилцуулж, мэдээлэл өгсөн.<br>СМТТ УТҮГ-т хүргүүлж, шийдвэрлүүлсэн асуудлууд:<br>1.ГИТ ААН-үүд тээврийн хэрэгсэл нэмүүлэх хүсэлтээ ГЕГ-т цаасаар хүргүүлэхгүйгээр цахимаар илгээх боломж бүрдүүлсэн;<br>2.тээврийн хэрэгслийн мэдээллийг баталсан, идэвхгүй, баталгаажуулахаар илгээсэн төлвүүдээр ялгаж харах боломжтой болгосон.<br>3.тээврийн хэрэгслийн жагсаалтыг дугаарлаж харагддаг болгосон; | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4.тээврийн хэрэгслийн мэдээллийг excel-рүү жагсаалтаар хөрвүүлдэг болгосон;<br>5.тээврийн хэрэгсэл нэмүүлэх хүсэлтээ license.mn-ээр илгээж, баталгаажсан төлөвт ороход ГИТ наалтад агуулагддаг мэдээлэл бүхий QR үүсдэг болгосон.<br>СМТТ УТҮГ-т хүргүүлээд, шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа саналууд:<br>1.ГИТ-ээс хүсэлт илгээсэн, баталгаажуулахаар илгээсэн төлөвтэй тээврийн хэрэгслийн давхардлыг арилгах. Цахим системд өөр ААН-д бүртгэлтэй гэх мэдээллийг зөвхөн баталгаажсан төлөвт байгаа мэдээллээс бүртгэх.<br>2.ГИТ-ийн хяналтыг сайжруулах зорилгоор ААН-д "хүсэлтийг буцаасан" мэдээлэл нь тухайн ААН-д бүртгэлтэй цахим хаягаар давхар илгээгддэг өөрчлөлт оруулах<br>3.цахимд хүсэлт илгээсэн ААН-ийн бичиг баримтын мэдээлэл дутуу тохиолдолд тайлбар бичээд тухайн ААН рүү хүсэлтийг буцаах үйлдэл хийгддэг. Энэ тохиолдолд буцаасан хүсэлтэд хариу ирүүлсэн хугацаанаас эхлэн шийдвэрлэлтийн хугацааг шинээр тоолуулах өөрчлөлт оруулах;<br>4.тээврийн хэрэгсэл нэмүүлэх, хасуулах хүсэлтийг 5 саналыг шийдвэрлүүлэхээр хамтран ажиллаж байна.хүлээн авч, шийдвэрлэх саналаа хүргүүлж, хөгжүүлэлтийг УТҮГ-т хийлгэсэн тул дээрх мэдээллийг хүлээн авч, уялдуулах ажил ГЕГ-ын МТГ-т хийгдэж байна.<br>5.ГИТ-ийн таних тэмдгийг QR болгох асуудлыг судлан, санал боловсруулж, СМТТ УТҮГ-т хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>1.Тусгай зөвшөөрлийн license.mof.gov.mn-д ирүүлсэн 199 хүсэлтийг хүлээн авч хянаад, ГЕГ-ын 2024 оны 1, 3, 5, 6, 9, 10 дугаар сарын МЗХ-д танилцуулж, шийдвэрлүүлсэн.<br>2.ГИТ-д тавьж байгаа хяналт, эрх зүйн зохицуулалтай холбоотой PPT бэлтгэж, удирдлагад 2024 оны 1, 9 дүгээр сард танилцуулж, мэдээлэл өгсөн.<br>3."Улс хооронд байнгын ачаа тээврийн зөвшөөрлийн бичиг олгох, тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих журам"-ын төсөлд оруулах 13 санал боловсруулж, удирдлагад танилцуулж, СЯ-д хүргүүлсэн.<br>4.СМТТ УТҮГ-т нийт 10 санал хүргүүлсэнээс, 5 санал шийдэгдсэн. | | |
| 4. | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтэд | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Горимын хэрэгжилтэд хяналт тавьж, гаалийн газар, хороодын | Тайлант хугацаанд 4 удаа CAIS-с гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимоор бүрдүүлэлт хийсэн мэдээллийг татаж, хаалт хийсэн эсэх талаар тодруулж хариу ирүүлэхийг харьяа гаалийн газар хороодод 02-1/2778, 02-1/1472- 02-1/02-1/1476, 02-1/4241, 02-1/4408, 02-1/4430, 02-1/4429, 02-1/4538, | 01.20<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавьж ажиллах. | | | дарга нарт чиглэл хүргүүлж ажиллана.<br>-CAIS-ыг сайжруулах санал боловсруулж, МТГ-т хүргүүлж, шийдвэрлүүлнэ.<br>-Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой ирүүлсэн хүсэлтийг хянаж, шийдвэрлүүлнэ. | 02-1/4077 тоотоор чиглэл хүргүүлсэн. Мөн горимд байрших хугацааг сунгах эсэх, горимтой холбоотой асуудлаар гаалийн газар хороодод 38 удаа албан бичгээр чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. ATA/CPD, ТИР карнейн гаалийн хяналтыг сайжруулж, ажиллах талаар 01-1/2093, 02-1/1967, 02-1/1968, 02/2490 тоотоор 4 удаа чиглэл хүргүүлсэн.<br>2.Гаалийн бүрдүүлэлтийн горимтой холбоотой асуудлаар CAIS-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ГЕГ-ын дэргэдэх МТГ-т 4 удаа дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>3.Гаалийн бүрдүүлэлтэй холбоотой асуудлаар 522 албан бичгээр ирүүлснээс гаалийн бүрдүүлэлтийн горимтой холбоотой асуудлаар ирүүлсэн 104 хүсэлтийг судлан, шаардлагатай тохиолдолд удирдлагад танилцуулан, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хүсэлтийг шийдвэрлэж, 53 албан бичиг боловсруулж, хариуг хүргүүлсэн.<br>Хүрсэн үр дүн:<br>1.Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түр горимоор бүрдүүлэлт хийсэн 161 мэдүүлгийг 300 горимоор, 230 мэдүүлгийг 420 горимоор хаалт хийснээс гадна 10-р сард хүргүүлсэн чиглэлээр 1151352 ам.долларын 38 барааг 300 горимоор 36 мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн бол 11 иргэн, хуулийн этгээдийн 490591 ам.долларын 27 нэрийн барааг 420 горимоор 15 гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийж, 279'016'760 төгрөгийн татварыг улсын төсвийн орлогод оруулсан байна.<br>Мөн Петрочайна ХХК-ийн 260394 ам.долларын 44 барааг 420 горимд байршуулж, 61916594 төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн.<br>CAIS-т 2024.05.17-ны байдлаар ЧХОУНБГГ-ын гаалийн хяналтад байсан 145 ATA карней, СЭГГ-ын хяналтад байсан 21 ATA карней, 10 CPD карнейн хаалт хийлгэсэн.<br>2.ХБГ-ын 2024.05.22-ны 208, 2024.06.10-ны 228, 2024.07.18-ны 295, 2024.11.18-ны 486 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн хүсэлтүүд хэрэгжсэн.<br>3.Гаалийн бүрдүүлэлтийн горимтой холбоотой асуудлаар 104 албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг судлан, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэсэн. | | |
| 5. | Оюуны өмч, тарифын бус хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Оюуны өмчийн хяналтыг сайжруулах сургалтыг гаалийн газар, хороодын ГУБ нарт зохион байгуулна. | 1.Тарифын бус хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах сургалтыг ГЕГ-ын БЦТ, ЗҮГГ, ЧХОУНБГГ, СТ-өөс зохион байгуулсан ГБМ, гаалийн анхан шатны мэдлэг олгох сургалтад оролцогч нарт 12 удаа нийт 1140 ГБМ, гаалийн албан хаагч нарт дараах сэдвээр зохион байгуулсан. Үүнд:<br>-БТКУС-ийн 93-р бүлэг "Зэвсэг, галт хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл ангилалд хамаарах бараа"-ны хяналт; | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | -Тарифын бус хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах сургалтыг зохион байгуулна.<br>-Оюуны өмч, тарифын бус хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг гаалийн газар, хороодын дарга нарт тухай бүр хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллана. | -Тарифын бус хязгаарлалтай бараанд тавих хяналт;<br>-Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтад хамрагдах бараа, тохирлын баталгаатай барааны хяналт, тээврийн хэрэгсэлд бүрдүүлэлт хийх горимын шаардлага, бүрдүүлэх бичиг баримт;<br>-Онцгой албан татвартай барааг гаальд мэдүүлэх.<br>Нэр бүхий компанийн тоглоомон буу хэмээн мэдүүлж, импортолсон 9304.00.00 ангиллын кодод хамаарах барааг НШШГ-аас ирүүлсэн албан бичгээр "галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлд хамаарахгүй" гэсэн дүгнэлтэд үндэслэн Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн 11.1, Галт зэвсгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заалт, МУ-ын ЗГ-ын 2002 оны 219 дүгээр тогтоолд хамааруулахгүй, тусгай зөвшөөрөл, лицензгүйгээр импортоор оруулсан бүрдүүлэлтийг шалгасан. Дээрх шалгалтын дүнд үндэслэн ХЗДХЯ, ЦЕГ-т 2024 оны 8, 9 дүгээр сарууддад 02/3147, 02/3581, 02/3582 дугаартай албан бичиг хүргүүлж, чиглэл авч, ГЕГ-ын БЦТ, УХШИГГ-т хууль тогтоомжийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх тухай чиглэлийг албан бичгээр хүргүүлж хяналтыг сайжруулсан.<br>2.АНУ-ын Патент, барааны тэмдгийн газар, АНУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-тай хамтарсан "Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт" сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 2024.04.25-ны өдөр зохион байгуулж, ГЕГ-ын ЗТГ, ЭУХ, БЦТ, МТГ, СТ, БДШГ, УБГГ, ЧХОУНБГГ, УХШИГГ, ГСГГ, СЭГГ, ДОГГ, ЗҮГГ, БӨГГ, ХОГГ-ын нийт 35 албан хаагчдыг оролцуулсан. Тус сургалтад АНУ-ын Нью Йорк мужийн Зүүн дүүргийн шүүхийн шүүгч Пэгги Куо, Патент, барааны тэмдгийн газрын Олон улсын харилцаа, бодлогын албаны Хуулийн хэлтсийн өмгөөлөгч-хуульч Марк Абумери, Аюулгүй байдлын мөрдөн шалгах албаны дэргэдэх Олон улсын Компьютер хаак, Оюуны өмчийн газрын тусгай төлөөлөгч Томас Софиа, Аюулгүй байдлын мөрдөн шалгах албаны Гуанжоу дэх Бүсийн дэд атташе Адам Жефферсон, Аюулгүй байдлын мөрдөн шалгах албаны Бээжин дэх Бүсийн дэд атташе Стивин Тимминс нар цахим орчин дахь эрхийн зөрчил, хуурамч барааг онилох, хуурамч барааг таних, хуурамч эмийн хил дамнасан худалдааг илрүүлж, таслан зогсоосон тодорхой тохиолдолд үндэслэн танилцуулга хийсэн. Мөн 2024.06.11-ний өдөр АНУ-ын ЭСЯ-ны дэд атташе Стивен Тимминс, Олон Улсын комьпютер хакердалт ба оюуны өмчийн асуудал хариуцсан зөвлөх Томас Софиа нартай уулзалт зохион байгуулж, цаашид Дэлхийн оюуны өмчийн өдөр болон Монгол Улсын оюуны өмчийг хамгаалах өдрийг тохиолдуулан жил бүрийн 4 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Хүрсэн үр дүн: | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1.Оюуны өмч, тарифын бус хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах зорилгоор гаалийн газар, хороод болон ГБМ, гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтад хамрагдаж буй 1223 хүнд нийт 57 цагийн хичээл зааж, мэдээлэл өгсөн.<br>2.Зэвсэг, галт хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл ангилалд хамаарах барааны хяналтыг сайжруулах зорилгоор судалгаа, дүн шинжилгээ хийж, ГЕГ-ын дэргэдэх БЦТ-д 321 дугаартай дотоод зурвасаар, гаалийн газар, хороодод 02-1/3140 албан бичгээр чиглэл өгч, хяналт тавьж ажиллаж байна.<br>3.Оюуны өмчийн эрхэд хамаарах барааны хяналтыг сайжруулах зорилгоор дээрх барааг бүртгүүлэх хүсэлтийг 2024.10.15-ны өдрөөс gaali.mn- ээр хүлээж аваад sims-т бүртгэдэг болгосон. Өнөөдрийн байдлаар CAIS-т дээрх мэдээллийг татаж, хяналтад ашиглуулах, мөн бүртгүүлэх хүсэлт илгээхэд өмнө нь гаальд бүртгэгдсэн барааны мэдээллийг хардаг болгох хөгжүүлэлтийг ГЕГ-ын МТГ-ын албан хаагч нараар хийлгэхээр ажиллаж байна.<br>4.Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан, ашигласан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрлийг цахимжуулан CAIS-т холбож, мэдээлэл солилцох системийг 2024.12.15-ны өдрөөс туршиж, 2025.01.01-ний өдрөөс нэвтрүүлэхээр БОУАӨЯ-ны ОУА-тай хамтран ажиллаж байна. | | |
| 6 | Гаалийн хяналтын тоног төхөөрөмж, эрэлч нохойг гаалийн хяналтад үр дүнтэй ашигласан байдал. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | -Боомтын шинэчлэлтэй уялдуулан шаардлагатай хяналтын тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, саналаа СХОГ-т хүргүүлнэ.<br>-Хяналтын тоног төхөөрөмж, эрэлч нохойг хяналтад үр дүнтэй ашиглах чиглэлийг гаалийн газар, хороодод хүргүүлнэ. | 1.Боомтын шинэчлэлтэй уялдуулан шаардлагатай хяналтын тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, саналаа СХОГ-т 2024.01, 04, 05, 06, 11 дүгээр саруудад 35, 156, 216, 248 дотоод зурвасаар:<br>-9 хилийн боомтод 2024 онд худалдан авах шаардлагатай 5 төрлийн 24 ш тоног төхөөрөмж,<br>-Хавирга, Баянхошуу, боомтод 40м*200тн, Цагааннуур боомтод 14м*150тн пүү;<br>-Бичигт боомтод шаардлагатай 7 төрлийн 20 тоног төхөөрөмж, RFID суурилуулахад шаардагдах 20 иж бүрдлийн жагсаалтыг хүргүүлсэн.<br>-Замын-Үүд боомт дахь 2203 м2 талбайтай байрыг нарийвчилсан шалгалтын зориулалтаар ашиглахаар төлөвлөсөнтэй холбогдуулан шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа, шаардлагатай энгэрийн камер, автопүү, рентгены тоог;<br>-харьяа гаалийн газар хороодын хяналт, шалгалтад ашиглах 7,325.2 төгрөгийн үнийн дүнтэй 10 төрлийн тоног төхөөрөмжийг | 01.02<br>12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар тус тус хүргүүлсэн.<br>2.Гаалийн хяналт шалгалтад хяналтын тоног төхөөрөмж, эрэлч нохой ашиглаж үр дүнг нэмэгдүүлэх чиглэлийг 2024 оны 1, 2, 4, 7, 12 дугаар саруудад 02-1/421, 462, 1542, 1637, 2728, 2768, 5009 дугаартай албан бичгээр хүргүүлэн хяналт тавьж ажилласан. ГУБ нарын рентгены дүрс зургийг таньж унших ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ИНҮТ-ийн НСТ-д "Тоног төхөөрөмж ашиглан үзлэг шалгалт хийх 16 цагийн хөтөлбөрт 90, ОХУ-ын ИСБА компани, ОХУ-ын Санкт-Петербург дахь Электотехникийн дээд сургуулийн багш нарын сургалтад 14 буюу нийт 104 албан хаагчдыг хамруулсан. ЗҮГГ-ын албан хаагч нарт тоон гарын үсгийн токен төхөөрөмжийг ашиглуулж эхэлсэнтэй холбогдуулан тус газарт хуваарилагдсан зөөврийн таблетыг ашиглах боломжгүй болсон тул УБГГ-т хуваарилсан 1 зөөврийн таблет /Zebra L 10 android rugged/-ыг МТГ-т хүргүүлж, асуудлыг яаралтай шийдвэрлүүлсэн. ГЕГ-ын дэргэдэх МТГ-т 2024.07.02-ны өдрийн 277 дугаартай дотоод зурвасаар санал хүргүүлэн, CAIS->Тээвэр->хэсэгт тээврийн хэрэгслийг рентгенээр шалгасан эсэх мэдээллийг оруулж, дүрс зургийг хавсаргах нэмэлт, өөрчлөлт оруулсан. ОХУ-ын ИСБ-А компанийн мэргэжилтэнүүдтэй хамтран ажиллаж, чингэлэг, ачааны тээврийн хэрэгсэл шалгах зориулалттай тус компанийн ИСБА Булган рентгены програмд нэмэлт, хөгжүүлэлт хийлгэх санал хүргүүлэн, зорчигчийн автобус, суудлын тээврийн хэрэгсэл, ачааны тээврийн хэрэгслийг жолоочийн хамт унших өөрчлөлтийг 2024 оны 8 дугаар сард хийлгэсэн. CAIS->Манифестын програмын дагалдах бичиг баримт хэсэгт ачаатай тээврийн хэрэгслийн дүрс зургийг файлаар хавсаргаж илгээдэг нэмэлт, өөрчлөлтийг оруулж, бүрдүүлэлтийн бүх шатанд рентген зургийг татаж харах боломжтой болгосноор рентген зургийн ашиглалтыг нэмэгдүүлсэн. Гаалийн газар, хороод рентгены ашиглалтын мэдээг өдөр бүр CERP-ийн Хилийн хөдөлгөөний мэдээ хэсэгт оруулах нэмэлт, өөрчлөлт хийлгэж, оруулсаны үр дүнд рентгены ашиглалтад өдөр тутам хяналт тавьж ажиллаж байна. Харьяа гаалийн 13 газар, хороодод 2024 оны жилийн эцсийн байдлаар 33 эрэлч нохойг гаалийн хяналт, шалгалтад ашиглаж 38 зөрчил илрүүлсэн. Албаны эрэлч нохойг гаалийн хяналтад ашиглаж 2023 онд 20 зөрчил илрүүлж байсан бол 2024 онд 38 зөрчил илрүүлсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 90% өссөн үзүүлэлттэй байна.<br>Хүрсэн үр дүн: | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1.Боомтын шинэчлэлтэй уялдуулан шаардлагатай хяналтын тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, саналаа СХОГ-т 5 удаа, мөн харьяа гаалийн газар хороодын хяналт, шалгалтад ашиглах 7,325.2 төгрөгийн үнийн дүнтэй 10 төрлийн тоног төхөөрөмжийг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар тус тус хүргүүлсэн.<br>2. 2024 оны жилийн эцсийн байдлаар харьяа гаалийн 13 газар, хороодод 33 эрэлч нохойг гаалийн хяналт, шалгалтад ашиглаж 38 зөрчил илрүүлсэн. Албаны эрэлч нохойг гаалийн хяналтад ашиглаж 2023 онд 20 зөрчил илрүүлж байсан бол 2024 онд 38 зөрчил илрүүлсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 90% өссөн үзүүлэлттэй байна.<br>3.Гаалийн газар, хороод рентгены ашиглалтын мэдээг өдөр бүр CERP-ийн Хилийн хөдөлгөөний мэдээ хэсэгт оруулах нэмэлт, өөрчлөлт хийлгэж, оруулсаны үр дүнд рентгены ашиглалтад өдөр тутам хяналт тавьж ажилладаг болсон;<br>4.CAIS->Манифестын програмын дагалдах бичиг баримт хэсэгт ачаатай тээврийн хэрэгслийн дүрс зургийг файлаар хавсаргаж илгээдэг нэмэлт, өөрчлөлтийг оруулж, бүрдүүлэлтийн бүх шатанд рентген зургийг татаж харах боломжтой болгосноор рентген зургийн ашиглалтыг нэмэгдүүлсэн.<br>5.Гаалийн хяналтад энгэрийн камерын ашиглалтыг нэмэгдүүлж, 7 хоног бүр CERP-д оруулсан бичлэг хүлээлцсэн тэмдэглэлийг хянадаг болсон. | | |
| 7 | Гадаад худалдааг хөнгөвчлөх. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | -Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны тайлан гарсан байна.<br>-Тайланг ГЕГ-ын МЗХ-д танилцуулж, бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах арга хэмжээг зохион байгуулна. | 1.Хилээр нэвтрүүлэх бараагаа зуучлагчаар дамжуулахгүйгээр gaali.mn өөрөө мэдүүлэх сургалтыг “Гаалийн бүрдүүлэлт, gaali.mn-ээр бараагаа мэдүүлэх” сэдвээр дараах байдлаар зохион байгуулж, гадаад худалдаанд оролцогч нарт мэдээлэл өгсөн:<br>-Соёлын төв өргөөнд Дадлага зөвлөх үйлчилгээний хүрээнд 2024.05.21-ний өдөр зохион байгуулагдсан Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 270 оролцогч;<br>-ШУТИС-ийн Механик тээврийн сургуульд 2024.10.29-ний өдөр зохион байгуулагдсан Тээвэр логистик сэдэвт сургалтад оролцсон 80 гадаад худалдаанд оролцогч ААН-ийн төлөөлөлд;<br>-ГЕГ-ын дэргэдэх СТ-өөс баталсан “Цахимаар бараагаа мэдүүлэх гадаад худалдаа эрхлэгч нарт зориулсан сургалт”-ын хичээлийн хуваарийн дагуу 2024.12.04-ний өдрийн 13:00-16:10 цагт нийт 18 хүнд.<br>Гадаад худалдаанд оролцогч нар 2023.01.01-2023.11.30-ны өдрийн байдлаар импортын 302705, экспортын 608886 мэдүүлгээр нийт 911591 гаалийн бүрдүүлэлт хийлгэсэн. Үүнээс экспортын 491061 буюу нийт экспортын мэдүүлгийн 80.6 %, | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | импортын 24225 буюу нийт импортын мэдүүлгийн 8 %-ийг gaali.mn-ээр өөрөө мэдүүлсэн байна.Харин 2024.01.01-2024.11.30-ны өдрийн байдлаар импортын 399560, экспортын 707489 мэдүүлгээр нийт 1107049 гаалийн бүрдүүлэлт хийлгэсэн. Үүнээс экспортын 558367 буюу нийт экспортын мэдүүлгийн 78.9 %, импортын 36021 буюу нийт импортын мэдүүлгийн 9.01 %-ийг gaali.mn-ээр өөрөө мэдүүлсэн байна. 2024 оны гаалийн нийт бүрдүүлэлтийг 2023 оны мөн үетэй харьцуулахад gaali.mn-ээр өөрөө мэдүүлсэн импортын бүрдүүлэлт 1.01 % өссөн, экспортын бүрдүүлэлт нь 1.7 % буурсан.<br>2.ГЕГ-ын дэд даргын 2023.10.24-ний өдөр баталсан удирдамжаар байгуулагдсан ажлын хэсэг "Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгаа"-г хийж, 2024.05.09-ний өдөр тайлангаа гарган, 2024.05.13-ны өдөр ГЕГ-ын онлайн хуралдаанаар танилцуулсан. Энэхүү судалгааны шинжилгээг дундаж утгын хүрээнд авч гүйцэтгэхэд 2023 онд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 8 % бууруулсан дүн гарсан. Гаалийн хяналтад байгаа барааны ББ-ын бүрдүүлэлтийг 2023.05.01-ний өдрөөс Улаанбаатар хотод төвлөрүүлсэнтэй холбоотойгоор 2023 онд ББ-ын бүрдүүлэлтэд зарцуулсан хугацаа 66% буурсан. Мөн суудлын автомашиныг системээс автоматаар үнэлэх түр заавры 2024.10.01-ний өдрөөс хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор хилээр оруулсан 807 суудлын автомашины ББ-ын бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж хугацаа 48 минут болж, 2023 онтой харьцуулахад 31% буурсан байна. CAIS-ийн Бүрдүүлэлтийн хугацаа програмаас 2022, 2003, 2024.11.06-11-ний өдрүүдийг сонгож, гаалийн бүрдүүлэлтийн мэдээг гарган, бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж хугацааг тооцоход гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж хугацаа нь жил бүр буурсан үзүүлэлттэй гарсан бөгөөд 2024 онд зарцуулсан хугацааг 2022 онтой харьцуулахад 42 %-аар буурсан байна.<br>3.ДГБ-ын ITDM хөтөлбөрийн хүрээнд ЭУХ-тэй хамтран харьяа УБГГ, ЗҮГГ, СЭГ-аас тус бүр 2, ЧХОУНБГГ, УХШИГГ, СШГГ, БИГГ, ХГГ, ДОГГ, БӨГГ-аас 40 албан хаагчдыг танхим болон цахимаар хамруулан "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилт хийх судалгааны арга зүй" чиглэлээр 2024.11.05, 06-ны өдрүүдэд сургалт зохион байгууллаа. Сургалтаар "Transport corridors customs organization modernization" "Цаг хугацааны хэмжилт хийх судалгааны арга зүй", "Global trend TRS", "Хиймэл оюун ухаан, Tableau ашиглан бүрдүүлэлтийн цаг хугацааг хэмжих нь" "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилт 2024" сэдвээр танилцуулга хийлээ. Мөн сургалтад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оролцогчдоор өгсөн мэдээлэл, зөвлөмжид тулгуурлан өөр өөрийн харьяалах гаалийн газар, хороодын 2023-2024 онд хийсэн гаалийн бүрдүүлэлтийн мэдээллээс гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан цаг хугацааны хэмжилт хийх практик дасгал хийлгэлээ.<br>Хүрсэн үр дүн:<br>1.“Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгаа”-аар 2023 онд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 8 % бууруулсан дүн гарсан.<br>2.Гаалийн хяналтад байгаа барааны ББ-ын бүрдүүлэлтийг 2023.05.01-ний өдрөөс Улаанбаатар хотод төвлөрүүлсэнтэй холбоотойгоор 2023 онд ББ-ын бүрдүүлэлтэд зарцуулсан хугацаа 66%-аар буурсан.<br>3.Суудлын автомашиныг системээс автоматаар үнэлэх түр заавлыг 2024.10.01-ний өдрөөс хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор хилээр оруулсан 807 суудлын автомашины ББ-ын бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж хугацаа 48 минут болж, 2023 онтой харьцуулахад 31 % буурсан байна.<br>4. 2024 оны гаалийн нийт бүрдүүлэлтийг 2023 оны мөн үетэй харьцуулахад gaali.mn-ээр өөрөө мэдүүлсэн импортын бүрдүүлэлт 1.01 % өссөн.<br>5.Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан цаг хугацааны судалгаа, тайланг Tableau Software ашиглан тогтмол хяналт тавих санал боловсруулж, МТГ-т 2024.11.10-ний өдөр хүргүүлэн, хамтран ажиллаж байна. | | |
| 8 | Гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд бүрдүүлэлт хийсэн байдалд тавих хяналт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлж ажиллана.<br>-CAIS-ыг сайжруулах чиглэлээр санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.<br>-Гаалийн мэдүүлэг, бүрдүүлэлтийн хуудсаар бүрдүүлэлт хийхтэй холбоотой ирүүлсэн хүсэлтийг хянаж, шийдвэрлүүлнэ. | Тайлангийн хугацаанд гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой 2 журмыг шинэчлэхээр төслийг шинэчлэн, ЗЕХ-ийн дагуу санал авахаар гаалийн цахим хуудаст байршуулснаас гадна төрийн бусад байгууллагаас ирүүлсэн 1 хуулийн төсөл, 4 журмын төсөлд, ГЕГ-ын ЗББНДБ-с ирүүлсэн 5 журмын төсөлд оруулах санал хүргүүлсэн.<br>ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан Гаалийн мэдүүлэг нөхөн бичих, шалгах заавaрт ГЕГ-ын даргын 2024.11.12-ны өдрийн А/611 дугаартай тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан.<br>1.Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын талаар Сангийн яам, УУХҮЯ-наас албан тоотоор тодруулга авсны дүнд ХХГ, БЦТ-д 02-1/1969, 02/2388-р чиглэл хүргүүлсэн.<br>2.Гаалийн мэдүүлгийг зохих төлөвт бүрэн байршуулах талаар 12,<br>3.Мэдүүлгийн алдааг залруулах талаар талаар 9,:<br>4.Зарим бараатай холбоотой 15 удаа албан бичгээр чиглэл өгч, сургалт хийсэн. | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2.Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотой CAIS-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ГЕГ-ын дэргэдэх МТГ-т 9 удаа дотоод зурвасаар санал хүргүүлсэн.<br>3.Гаалийн бүрдүүлэлтэй холбоотой асуудлаар 418 албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг судлан, шаардлагатай тохиолдолд удирдлагад танилцуулан, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хүсэлтийг шийдвэрлэж, 164 албан бичиг боловсруулж, хариуг хүргүүлсэн.<br>Хүрсэн үр дүн:<br>1.Уул уурхайн биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2.“Гаалийн хяналтад байгаа” төлөвтэй экспортын барааны 127 гаалийн мэдүүлгийг “Гааль зөвшөөрөв” төлөвт оруулсан.<br>3.Экспортын барааны цэвэр жин зөрүүтэй бүрдүүлэлт хийсэн 48 мэдүүлгийн алдааг залруулсан.<br>4.Хүнсний бүтээгдэхүүний гаалийн мэдүүлэгт тухайн барааны үйлдвэрлэсэн огноо болон хадгалах хугацааг бичиж бүрдүүлэлт хийдэг болсон.<br>5.ХБГ-ын 2024.02.27-ны 91, 2024.05.13-ны 151, 2024.05.24-ны 209, 2024.07.30-ны 309 дугаартай дотоод зурвасаар ГЕГ-ын МТГ-т хүргүүлсэн хүсэлтүүд шийдэгдсэн. | | |
| 9 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлнэ. | Дараах бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлтийг гаргаж, ГЕГ-ын ЗУГ-т хугацаанд нь, ХХ-т сар бүр тогтмол хүргүүлсэн:<br>УИХ-ЫН ТОГТООЛ:<br>-2022 оны Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 72;<br>-2023 оны Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2023 оны 06;<br>УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ:<br>-Чиглэл өгөх тухай 2020 оны 10;<br>ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:<br>-2022.01.16-ны 53 дугаар тогтоолын 3;<br>-2022.09.05-ны 335 дугаар тогтоолын 2,3;<br>-2022.10.05-ны 362 дугаар тогтоолын 1, 3;<br>-2022.11.23-ны 412 дугаар тогтоолын 2;<br>-2022.12.14-ний 466 дугаар тогтоолын 2,4;<br>-2023.01.11-ний 20 дугаар тогтоолын 2;<br>-2024.02.14-ний 60 дугаар тогтоолын 2;<br>-2023.04.19-ний 146 дугаар тогтоолын 2; | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -2023.05.03-ны 159 дүгээр тогтоолын 1;<br>-2023.05.17-ны 178 дугаар тогтоолын 1, 1.4, 3.1;<br>-2023.06.21-ний 233 дугаар тогтоолын 7;<br>-2023.07.05-ны Зарим компанид тусгай зөвшөөрөл олгох тухай 270 дугаар тогтоолын 2;<br>-2024.04.10-ны 150 дугаар тогтоолын 4;<br>ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭМДЭГЛЭЛ:<br>-2022.05.11-ний 28-р тэмдэглэлийн XYI.4;<br>-2023.05.03-ны 19-р тэмдэглэлийн XYIII.2.1, XYIII.2.2, XYIII.2.3;<br>-2023.07.26-ны 30-р тэмдэглэлийн 1.1, 3.3;<br>-2023.09.06-ны 36-р тэмдэглэлийн 3.3;<br>-2023.10.04-ний 40-р тэмдэглэлийн 1, 2;<br>-2023.09.20-ны 38-р тэмдэглэлийн XII.7.15;<br>-2023.11.01-ний 44-р тэмдэглэлийн 2, 3, 4;<br>-2023.12.13-ны 50-р тэмдэглэлийн XVII.1.1;<br>-2023.12.20-ны 51-р тэмдэглэлийн XXV.5.3;<br>-2024.05.15-ны 19-р тэмдэглэлийн 1;<br>ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР:<br>-2022.12.16-ны 10-р даалгаврын 2, 3;<br>-2024.01.12-ны 01-р даалгаврын 1.7, 1.8;<br>ЕРӨНХИЙ САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР:<br>-2024.11.16-ны 10-р албан даалгаврын 1, 2, 3;<br>ХӨТӨЛБӨР:<br>-Гаалийн байгууллагын 2024 оны “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 1.1.5 дугаар биелэлтийн тайланг 2024 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргаж, 2024.06.13, 2024 оны 12 дугаар сард ЗУГ-т дотоод зурвасаар;<br>-Гаалийн байгууллагын 2024 оны эхний хагас жил, жилийн эцсийн үйл ажиллагааны Ил тод байдлын тайлангийн 1.3, 1.5, 1.8 дугаар үзүүлэлтийн биелэлтийг гаргаж, 2024.06.20, 2024 оны 12 дугаар сард ЗУГ-т spark-аар;<br>-Гаалийн байгууллагын “Шударга байдлын үнэлгээ”-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний 1.6-д заасан арга хэмжээний биелэлтийг 2024 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргаж, 2024.06.20, 2024 оны 12 дугаар сард ЗУГ-т;<br>-АТГ-аас ГЕГ-т ирүүлсэн 3-р зөвлөмжийн биелэлтийг 2024 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргаж, 2024.06.20, 2024 оны 12 дугаар сард ЗУГ-т;<br>-Шинэ сэргэлтийн бодлогын 1.1.8, 1.1.10 дахь арга хэмжээний биелэлтийг 2024 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар 2 удаа гаргаж, 2024.06.24, 2024.12.05-ны өдрүүдэд ЗУГ-т; | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Алсын хараа 2050-ын 4.4, 4.4.2 дахь арга хэмжээний биелэлтийг 2024 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар 2 удаа гаргаж, 2024.06.24, 2024.12.05-ны өдрүүдэд ЗУГ-т хүргүүлсэн.<br>Хүрсэн үр дүн.<br>1.Сангийн яаманд хүргүүлэх УИХ-ын 2 тогтоол, УИХ-ын Байнгын хорооны 1 тогтоол, Засгийн газрын 13 тогтоол, 10 тэмдэглэл, 3 албан даалгаврын нийт 40-45 заалтын хэрэгжилтийг сар бүр гаргаж, дараа сарын 01-ний өдрийн дотор ГЕГ-ын ХХ-т тогтмол хүргүүлсэн.<br>2.Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг ЗУГ-т тухай бүр гаргаж, хугацаанд нь spark-аар хүргүүлэн ажилласан. | | |
| 10 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулж, ХЗДХЯ-д хүргүүлнэ.<br>-ГББ-ийн горимын журамд нэмэлт оруулж, ХЗДХЯ-д хүргүүлж хянуулна.<br>-Ухаалаг гарцын тоног төхөөрөмж ашиглах зааврыг батлуулна.<br>-Нийтлэг журамд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, МЗХ-д танилцуулж, шийдвэрлүүлнэ.<br>-ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, МЗХ-д танилцуулж, шийдвэрлүүлнэ. | 1.ГЕГ-ын даргын 2023.12.20-ны өдрийн А/680 дугаар тушаалын хавсралтаар шинэчлэн батлуулсан гаалийн баталгаат бүсийн горим хэрэгжүүлэх журмуудыг ХЗДХЯ-аас 2024.01.22-ны өдрийн 1-292 дугаартай албан бичгээр Зөвшөөрлийн тухай хуулинд нийцүүл гэсэн дүгнэлт ирүүлсэн. Гэвч Гаалийн тухай хуулинд тусгагдсан гаалийн баталгаат агуулахын горим хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтуудыг үндэслэсэн журмын холбогдох заалтуудыг хасах нь үндэслэлгүй учраас Гаалийн тухай хуулийн 139, 140, 145, 152, 159, 166-д нэмэлт оруулах саналыг 2024.10.17-ны өдөр СЯ-аар уламжлуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>2.ГЕГ-ын даргын 2024 оны А/532 дугаар тушаалын хавсралтаар "Гаалийн хяналт, шалгалтад ухаалаг гарцын тоног төхөөрөмж ашиглах заавар"-ыг батлуулан хяналт тавьж ажиллаж байна. Энэхүү зааврaар автозамын хилийн боомтоор нэвтрүүлэх, гаалийн хяналтын бүсэд оруулах, гаргах тээврийн хэрэгслийн бүртгэлийг цахимжуулж, хяналтыг сайжруулах зорилгоор RFID (Radio Frequency Identification Data) радио давтамжит долгион бүхий тоног төхөөрөмжөөр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж, мэдээллийг гаалийн байгууллагад илгээх, гаалийн байгууллагаас илгээсэн хариу мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд боловсруулалт хийж жолоочид мэдээлэл хүргүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулна.<br>3.МУ-ын ДШЗХТ-ын 2023.12.25-ны өдрийн 02-р тогтоолын дагуу ГЕГ-ын даргын 2019 оны А/282 дугаартай тушаалаар батлагдсан "Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах ГЕГ-ын даргын 2024 оны А/338 дугаар тушаалыг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Дээрх тушаалаар ГЕГ-ын даргын 2019 оны А/223 дугаар тушаалаар батлагдсан Зорчигчийн журмын 2.3.1-д заасан | 01.02<br>12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | барааг чөлөөт бүсэд зорчигчдийн худалдан авалтын давтамжийг бууруулж, татвараас зайлсхийх нөхцөл байдал үүсгэхгүй болгох зорилготой зохицуулалтыг тусгасан.<br>4.ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаартай тушаалаар батлагдсан хяналтын нийтлэг журмын төслийг боловсруулж, ГЕГ-ын бүтцийн нэгж, харьяа гаалийн газар, хороодын дарга нарт албан бичгийн хавсралтаар хүргүүлж, мөн гаалийн байгууллагын customs.gov.mn-д байршуулж олон нийтээс санал авч, ГЕГ-ын МЗХ-д танилцуулахад бэлтгэсэн. Гэвч дээрх журмын төсөлд холбогдох зохицуулалтуудыг нарийвчлан тусгаж, төслийг АТГ-т хүргүүлж, хянуулах хүргийг АТГ-аас 2024.10.31-ний өдрийн 01/17563 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Иймд дээрх төсөлд дахин нэмэлт оруулж, АТГ-т хүргүүлж, хянуулахаар ажиллаж байна.<br>5.ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан Гаалийн мэдүүлгийг нөхөн бичих заавар", Гаалийн мэдүүлгийг шалгах заавар"-ыг шинэчлэхээр төслийг гаалийн цахим хуудаст байршуулан Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээс санал авч байна.<br>Хүрсэн түвшин:<br>1.ГЕГ-ын даргын 2023.12.20-ны өдрийн А/680 дугаар тушаалын хавсралтаар шинэчлэн батлуулсан гаалийн баталгаат бүсийн горим хэрэгжүүлэх журмуудыг ХЗДХЯ-аас 2024.01.22-ны өдрийн 1-292 дугаартай албан бичгээр Зөвшөөрлийн тухай хуулинд нийцүүл гэсэн дүгнэлт ирүүлсэн. Гэвч Гаалийн тухай хуулинд тусгагдсан гаалийн баталгаат агуулахын горим хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтуудыг үндэслэсэн журмын холбогдох заалтуудыг хасах нь үндэслэлгүй учраас Гаалийн тухай хуулийн 139, 140, 145, 152, 159, 166-д нэмэлт оруулах саналыг 2024.10.17-ны өдөр СЯ-аар уламжлуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>2.ГЕГ-ын даргын 2024 оны А/532 дугаар тушаалын хавсралтаар "Гаалийн хяналт, шалгалтад ухаалаг гарцын тоног төхөөрөмж ашиглах заавар"-ыг батлуулан хяналт тавьж ажиллаж байна.<br>3.ГЕГ-ын даргын 2019 оны А/282 дугаартай тушаалаар батлагдсан "Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах ГЕГ-ын даргын 2024 оны А/338 дугаар тушаалыг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.<br>4.ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан гаалийн мэдүүлгийн үндсэн маягтын "18.барааны байршил" талбарт нэг багана нэмэх, тушаалын 4-р хавсралтаар батлагдсан гаалийн мэдүүлгийг нөхөн бичих зааврын 18.Барааны байршил хэсгийг өөрчлөн найруулж, ГЕГ- | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сул тал /хүндрэлтэй асуудал/:<br>1.Шаардлагатай мэдээ тайлан богино хугацаанд гаргахад эрхийн хязгаарлалтай байдаг. Тухайлбал сар бүр Сангийн яаманд гаргаж хүргүүлдэг Гэрээ бүртгэлийн нэгдсэн системээс гаргах тоон мэдээллийг авах эрх байхгүй учраас СМТТ УТҮГ-т хандаж, тодорхойгүй хугацаагаар хүлээдэг;<br>2.Квот, ГИТ, гаалийн мэдүүлгийг татгалзах, хүчингүй төлөвт шилжүүлэх, горимд байршуулах хугацаа сунгах зэрэг нэгжийн чиг үүргийн дагуу зөвхөн тухайн асуудлыг хариуцсан ГУБ нарт байх шаардлагатай эрхүүдийг өөр бусад албан хаагч нар ашиглах боломжтой байгаа эсэхийг хянах боломжгүй байдаг;<br>3.CAIS-т нэвтрэхдээ тоон гарын үсэг ашиглахгүй байгаа нь нууцлал, аюулгүй байдлыг хангахгүй;<br>4.CAIS-аас шаардлагатай мэдээг татаж чаддаггүй, гар ажиллагаа ихтэй;<br>5. Сангийн яамнаас мэдээ, биелэлтийг хугацааг нь тулгаж, 2 цагийн дотор ирүүл эсхүл 10:10 цагт өгөөд 13:30 цагаас өмнө ирүүл гэх мэтээр шаарддаг.<br>Хүрсэн үр дүн:<br>1.ХБГ-ын гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэлийг.<br>-Бүтэц зохион байгуулалт;<br>-Үйл ажиллагаа;<br>-Хууль тогтоомж;<br>-Мэдээллийн технологи гэсэн 4 чиглэлээр тодорхойлж гаргасан.<br>2.Хяналт, бүрдүүлэлтийн газрын үйл ажиллагааг тогтвортой зохион байгуулахын тулд дээрх эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйл бүртэй холбоотой эрсдэл гарах магадлал, үр дагаврыг 3х3 матрицын тусламжтай гаргасан.<br>3.Нийт 4 хүчин зүйлийн хүрээнд тодорхойлсон 8 эрсдэлээс 5 нь хамгийн өндөр, 3 нь бага эрсдэлийн зэрэглэлтэй гэж үнэлэгдсэн тул хүчин зүйл тус бүрийн хүрээнд тодорхойлсон эрсдэлийг бууруулах арга хэмжээ тус бүрийг хариуцах нэгж, хамтран хэрэгжүүлэгчийг тодорхойлж, бууруулах чиглэлээр ажиллаж байна. | | |
| 12 | Үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | | ХБГ-ын 2024 онд нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч маш их цаг хугацаа зарцуулдаг, удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй дараах үүргийг цаг хугацаанд нь гүйцэтгэж ажилласан. Үүнд:<br>ХБГ-ын албан хаагч нар 2024 онд Замын-Үүд боомтод 8, Гашуунсухайт боомтод 5, Алтанбулаг, Ханги боомтуудад 2, Шивээхүрэн, Булган боомт, ДОГГ, СШГГ, ХГГ, Дархан-Уул аймагт тус бүр 1 буюу нийт 21 удаа тус тус томилолтоор ажилласан. | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХБГ-ын албан хаагч нар 2023, 2024 онд төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагуудад зохион байгуулагдсан 52 удаагийн уулзалт, хурал, хэлэлцүүлэгт удирдлагын шийдвэрээр гаалийн байгууллагыг төлөөлөн оролцож, гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой асуудлаар санал солилцож, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>ГЕГ-ын даргын тушаал, ГЕГ-ын дарга, дэд даргын баталсан удирдамжийн дагуу 2024 онд ХБГ-ын албан хаагч нараас 17 ажлын хэсэгт ажилласан.<br>ХБГ-ын албан хаагч нар 2024 онд төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагын 25 ажлын хэсэгт удирдлагын шийдвэрээр гаалийн байгууллагыг төлөөлөн ажиллаж, гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой асуудлаар санал солилцож, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаж байна. Мөн ГЕГ-ын удирдлагуудаас ажиллах ажлын хэсгүүдэд удирдлагын шийдвэрээр орлож оролцох, ажлын хэсгийн нарийн бичигт хүргүүлэх санал, мэдээллийг бэлтгэж өгөх зэргээр ажилласан.<br>ГХЯ, ЭЗХЯ-аас ирүүлсэн 4 төлөвлөгөө, хуралдааны протоколын биелэлтийг ХБГ-аас 7 удаа бэлтгэж, хүргүүлсэн.<br>ХБГ-аас 2024 онд 16 удаа 111 цагийн сургалт зохион байгуулж, гадаад худалдаанд оролцогч болон ГБМ, гаалийн анхан шатны сургалтад оролцогч, харьяа гаалийн гаалийн газар, хороодын нийт 1732 албан хаагч, ажилтаныг хамруулсан.<br>ХБГ-аас цаг үеийн асуудлаар 8 удаа танилцуулга боловсруулж, бэлтгэн удирдлагад танилцуулсан.<br>Бусад байгууллагаас гаалийн байгууллагад ирүүлсэн 6 төсөлтэй танилцаж, санал боловсруулж хүргүүлсэн.<br>МҮОНТ-ийн зочны цаг шууд ярилцлагад 2024.11.01-ний өдөр оролцож, улсын хилээр нэвтрүүлж байгаа тээврийн хэрэгслийн шалгалтад гаалийн хяналтын тоног төхөөрөмж ашиглаж байгаа талаар мэдээлэл өгсөн.<br>Хүрсэн үр дүн:<br>1.Гаалийн газар, хороодод 21 удаа томилолтоор ажилласан;<br>2.Төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагуудад зохион байгуулагдсан 52 удаагийн уулзалт, хуралд оролцсон;<br>3.Төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагын 25 ажлын хэсэгт ажилласан;<br>4.ГХЯ, ЭЗХЯ-аас ирүүлсэн 4 төлөвлөгөө, хуралдааны протоколын биелэлтийг ХБГ-аас 7 удаа бэлтгэж, хүргүүлсэн;<br>5.Гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой асуудлаар нийт 16 удаа 111 цагийн сургалт зохион байгуулж, гадаад худалдаанд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оролцогч болон ГБМ, гаалийн анхан шатны сургалтад оролцогч, харьяа гаалийн гаалийн газар, хороодын нийт 1732 албан хаагч, ажилтаныг хамруулсан;<br>6.Цаг үеийн асуудлаар 8 удаа танилцуулга боловсруулж, бэлтгэн удирдлагад танилцуулсан;<br>7.Бусад байгууллагаас гаалийн байгууллагад ирүүлсэн 6 төсөлтэй танилцаж, санал боловсруулж хүргүүлсэн. | | |
| 13 | Ажлын цаг ашиглалт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Нийт албан хаагч нарын ажлын цаг ашиглалтыг сайжруулж ажиллана. | Албан хаагч нарын цагийн бүртгэлд хяналт тавьж ажилласан. 2024 онд ХБГ-ын албан хаагч нарын томилолтоор ажиллах 40, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 79, ээлжийн амралтын 20, чөлөөний 7, хурлын өрөөний 26, бусад 67 буюу нийт 245 хүсэлтийг тус тус CERP-ээр илгээснийг хянасан. | 01.02<br>12.10 | 100 |
| 14 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГХБ-д ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулж, хяналтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.<br>-Алтанбулаг, Баянхошуу, Гашуунсухайт боомтуудад ухаалаг гарцын системийг нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмж: Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийн хүрээнд боомт руу орох, гарах хаалга болон боомт доторх замын эгнээнүүд дээр RFID-г суурилуулж, боомтын тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг сайжруулахаар ажиллаж байна.<br>Хилийн боомт:<br>-Гашуунсухайт боомтын нүүрсний терминалын экспортын хэсгийн 4, импортын хэсгийн 3 эгнээ замд тус бүрт нь RFID-г түр суурилуулан 2023.02.17-ны өдрөөс эхлэн өдөртөө хилээр гарч байгаа нүүрс ачсан тээврийн хэрэгслүүдийг бүртгэсэн. Тус боомтын шинэчлэл, бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор өнөөдрийн байдлаар нүүрсний гарах хэсэгт хяналтын бүсрүү орох 2, хяналт шалгалтын саравч доор суурилуулсан 4 ухаалаг гарцыг тогтмол ашиглаж байна. Гашуунсухайт боомтод 2024.11.30-ны өдрийн байдлаар нүүрсний терминалын 35, зорчигчийн терминалын 20, зэсийн баяжмалын хэсэгт 4 буюу нийт 59 эгнээ, замд RFID-г суурилуулахаас 57 гарцад суурилуулсан төхөөрөмжийг гүйцэтгэгч компаниас хүлээж авсан. Хилээр гарах талын рентген, дээж авагчийн ухаалга гарцын ажил нь хүлээгдэж байна.<br>-Шивээхүрэн боомтын нүүрсний терминалын гарах хэсэгт 7, орох чиглэлийн 3 хэсэгт суурилуулсан RFID-ээр 2023.10.25-ны өдрөөс эхлэн тус боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийг бүртгэж байна.<br>-Замын-Үүд боомтын зорчигч тээврийн терминалд 54, ачааны терминалын 39 байршилд ухаалаг гарцын системын тоног төхөөрөмжийг 2023.01.08-ны өдөр хийж суурилуулж, дуусгасан. Ачааны терминалын үйл ажиллагааг 2023.11.27-ны өдрөөс эхлүүлж, 14 байршилд суурилуулсан RFID-ээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж байна. | 01.02<br>12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Ханги: ГЕГ-ын даргын 2024.11.25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг ажиллаж, тус боомтод 11 байршилд суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг шалган, 2024.12.10-ны өдрөөс тээврийн хэрэгслийг RFID-ээр бүртгэх ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.<br>Гүний гаалийн хяналтын бүс:<br>ГХБ-д оруулж, гаргаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэх RFID-г суурилуулж, бодит цагийн горимд СМТТ УТҮГ-ын smartgate.ecustoms.mn системд холбуулах даалгаврыг 2024.02.28-ны өдрийн 02-1/762 дугаартай албан бичгээр ГХБ эзэмшигч нарт хүргүүлсэн. Дээрх ажилтай холбогдуулан RFID болон системд тавигдах шаардлагыг gaali.mn -ын "Гарын авлага, заавар" хэсэгт байршуулж, мэдээлэл өгч, албан даалгаврын хүрээнд УБГГ-ын хяналтад үйл ажиллагаа явуулж байгаа ГХБ эрхлэгч нартай 3 удаа уулзалт зохион байгуулсан. Өнөөдрийн байдлаар:<br>-АБТЭМА, Монголтранс, Туушин ГХБ-д суурилуулсан;<br>-Бусад ГХБ-д RFID-г суурилуулахад 55-70 орчим сая төгрөгийн зардал гарахаар тооцоолол гарсан тул судалж байна гэсэн хариу ирүүлсэн. RFID-г Цагаанхад суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа 27 ГХБ-д суурилуулсан, үйл ажиллагаа явуулахгүй байгаа 14 ГХБ-д суурилуулаагүй буюу тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа ГХБ-ийн 93% нь RFID суурилуулсан.<br>Шивээхүрэн боомтоор нүүрс экспортлогч 6 компани уурхай дахь талбайд RFID-г бүрэн суурилуулсан. СМТТ УТҮГ-тай холбогдон програмын хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>1.Гашуунсухайт боомтын нүүрсний терминалын 7 эгнээ замд тус бүрт нь RFID-г түр суурилуулан хилээр гарч байгаа нүүрс ачсан тээврийн хэрэгслүүдийг бүртгэсэн. Гашуунсухайт боомтод 2024.11.30-ны өдрийн байдлаар нүүрс, зорчигч, зэсийн баяжмалын хэсэгт нийт 59 эгнээ, замд RFID-г суурилуулахаас 57 гарцад суурилуулсан төхөөрөмжийг гүйцэтгэгч компаниас хүлээж авсан.<br>2.УБГГ, ГСГГ-ын хяналтад үйл ажиллагаа явуулдаг 30 ГХБ-д RFID-г суурилуулсан.<br>3.Алтанбулаг боомтод RFID суурилуулах ажлыг RIBS төслөөр хэрэгжүүлэхээр тендер, сонгон шалгаруулалт явагдаж байгаа тул энэ ажил гаалийн байгууллагаас шалтгаалахгүй.<br>4.Баянхошуу боомтын бүтээн байгуулалт эхлээгүй тул RFID суурилуулах ажил хийгдээгүй нь гаалийн байгууллагаас шалтгаалахгүй. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ын даргын 2024.11.12-ны өдрийн А/611 дугаартай тушаалаар баталж, заавварт шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан. | | |
| 11 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | -Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар ЭУХ-ээс зөвлөгөө, чиглэл авах ажлыг зохион байгуулна. | Нэгжийн чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлж, дараах чиглэлээр судалгаа хийсэн. Үүнд:<br>1.Хүний нөөц, бүтэц, зохион байгуулалттай холбоотой эрсдэл тооцох;<br>2.Нэгжийн үндсэн чиг үүрэг, чиг үүргийн харьцуулалт;<br>3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлаас гадуур болон цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн ажил;<br>4.Нэг албан хаагчид ногдох ажлын ачаалалтай холбоотойгоор ажлын цаг ашиглалт, илүү цаг болон бусад дотоод ажил;<br>5.Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан байдал.<br>Тус нэгжийн албан хаагч нар олон чиглэл хариуцаж, чиглэл тус бүрийг нарийвчлан судлах шаардлагатай байдаг. Иймд чиг үүргийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг дараах байдлаар тооцоолж,<br>-эрсдэлийн зэрэглэл өндөр үнэлэгдсэн тохиолдолд түүнийг бууруулах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх;<br>-дунд түвшинд үнэлэгдсэн тохиолдолд байнга хяналт тавьж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>-бага түвшинд үнэлэгдсэн тохиолдолд эрсдэлийг тасралтгүйгээр хянан үзэхээр ажиллаж байна. Мөн нэгжийн давуу болон сул тал, хүндрэлтэй асуудлуудыг таньж, тогтоон хянаж ажиллаж байна. Давуу тал:<br>1.Багаар ажиллаж, ажиллагсад хоорондын ажил үүргийг орлон гүйцэтгэх чадвартай албан хаагч нар ажилладаг;<br>2.Албан тушаалын чиг үүргийн хүрээнд авилга, ашиг сонирхлоос ангид байж, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигладаггүй;<br>3.Гаалийн байгууллагын бодлого, чиглэлийг тодорхойлоход дэмжлэг болох мөн чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, танилцуулгыг цаг тухай бүр ажил, амралтын цаг харгалзахгүйгээр гаргаж удирдлагад хүргүүлдэг;<br>4.Ажлын ачаалал даах чадвартай. Энэ нь албан хаагч нарын “Ажлын зураг авалтын хуудас”-аас харагдана;<br>5.Ажлын бус цагаар, амралтын өдрүүдээр яаралтай мэдээ, танилцуулга бэлтгэх шаардлага тулгарахад шалтгаан тоочихгүйгээр тухай бүр ажиллаж чаддаг;<br>6.Шаардлага тохиолдсон үед эсхүл хэн нэг нь ачаалал ихтэй байх үед өөрийн чадахаар нэг нэгэндээ туслаж, ачааллаас нь хуваалцдаг. | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, солилцох мэдээллийг тохирсон байна.<br>-Ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг ижилсгэсэн байна. | -Хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн зөрүү гаргахгүй, мөн хилийн хяналтын байгууллагуудын давхардсан шалгалтыг багасгаж, хяналтаа сайжруулахын тулд автозамын хилийн боомтууд дээр гаалийн байгууллага болон хил хамгаалах байгууллагын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг уялдуулахаар хамтран ажиллаж байна. Дээрх ажлыг хэрэгжүүлэхээр ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, гаалийн байгууллагаас:<br>1.тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг өгөгдөл дамжуулах байдлаар илгээж, танай байгууллагаас тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарын тодорхой мэдээллийг хүлээн авах;<br>2.хилээр түр хугацаагаар тээврийн хэрэгсэл оруулсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн хилээр гарах үед нь түр хугацаагаар оруулсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг шалгаж, нягтлах зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан. Үүний үр дүнд улсын хилээр орох болон гарах талд хил нэвтэрсэн авто тээврийн хэрэгслийн дугаараар ХХЕГ-аас сервисээр мэдээлэл татах боломжийг бүрдүүлсэн. Тус мэдээлэлд жолооч, зорчигчийн овог, нэр, регистрийн дугаар, гадаад паспортын дугаар, төрсөн он сар өдрөөр Хил хамгаалах ерөнхий газрын баталгаажуулсан мэдээллийг хүлээн авч гаалийн хяналт шалгалтад ашиглах, эрсдэл тооцох боломжтой болгосон. Мөн цаашид төмөр зам, агаарын тээврийн хэрэгслээр хил нэвтэрсэн зорчигчийн мэдээллийг Хил хамгаалах байгууллагын баталгаажуулсан мэдээллийг авахаар ажиллаж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>1.ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж, хамтарсан уулзалт зохион байгуулан, сервисын мэдээллээ дахин шинэчилж хүргүүлсэн.<br>2.Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх ХУН төслийн хүрээнд программ хийлгэж, автозамын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл солилцох туршилтыг 2024 оны 11 дүгээр сард Замын-Үүд боомтод хийж, нэвтрүүлсэн. | 01.02<br>12.10 | 90 |
| 16 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS | Автозамын хилийн боомтуудаар нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг сайжруулах зорилгоор бүртгэлийг ухаалаг гарцын тоног төхөөрөмжөөр бүртгэх ажлыг боомтын шинэчлэлтэй уялдуулан Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад үе шаттайгаар хэрэгжүүлж байна. | 01.02<br>12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх бодлогын даалгавар боловсруулж, МТГ-т хүргүүлнэ.<br>-Мобайл аппликейшн туршилтаар ашиглана. | Улсын хилээр түр хугацаанд нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэл хил нэвтрэх хүсэлтийг ceps.gaali.mn вэб сайтаар хандаж илгээж байна. Тус бүртгэлийг илгээх тээврийн хэрэгслийн жолооч, тээвэрлэгч байгууллага нь хил дээр зөөврийн компьютер байнга ашиглах хүндрэлтэй нөхцөл байдал үүсэх, гар утаснаас холбогдсон тохиолдолд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн серийн дугаарын үсгийг латин болон крилл үсэг холих зэрэг шалтгаанаар бүртгэлийг алдаатай илгээж хил нэвтрэлтийг удаашруулах, улмаар гаалийн байгууллага дээрх бүртгэлийг хийх зэрэг нөхцөл байдал үүсээд байна.<br>Иймд Улсын хилээр түр хугацаанд нэвтэрч байгаа гадаад, дотоодын тээврийн хэрэгслийн улсын хилээр нэвтрэх бүртгэлийн хүсэлтийг гаалийн байгууллагад илгээх гар утсанд зориулсан програм хангамжийн хөгжүүлэлт хийлгэх шийдлийг судалж, СМТТ УТҮГ-т саналаа 2024.09.24-ний өдрийн 02-1/3895 дугаартай албан бичгээр хүргүүлж, хамтран ажилласан.<br>Дээрх асуудлыг ГЕГ-ын дэргэдэх МТГ-т шийдвэрлэх боломжгүй тул И-Монгол Академи УТҮГ-ын систем нэгтгэлийн газрын төслийн менежер С.Цэвээнсүрэн, системийн шинжээч А.Эрдэнэцэцэг, цахим засаглалын хэлтсийн процесс аналист Г. Будням, шинжээч Г.Оюунгэрэл нартай уулзалт зохион байгуулж, Е-Монголиа арр-д улсын хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч, гаалийн байгууллагатай холбогдох модул гаргуулахаар тохиролцсон.<br>Үүний дагуу тээвэрлэгчээс хил нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн хүсэлт илгээх асуудлыг гар утасны програм хангамжид суурилсан хэлбэрээр цахим төлбөрийн баримтын ebarimt системээс шийдвэрлэх технологийн гарц, шийдлийг судалж, И Монгол Академи УТҮГ-т захиалагчийн шаардлага, процессын зураглалыг тайлбарын хамт хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>1.Цаашид боомтын орох, гарах хаалганы эгнээ замууд дээр бүртгэлтэй холбоотой асуудлаар бөөгнөрөл үүсгэхгүйн тулд тээврийн хэрэгслийн жолооч нар гар утаснаасаа бүртгүүлэх хүсэлтээ илгээх боломжийг бүрдүүлэхээр гар утасны апп шинээр хийлгэхийн тулд үнийн дүнгээс шалтгаалаад цахим хуудсаар дамжуулан тендер зарлах гэх мэтээр улсын төсвөөс тодорхой хэмжээний зардал гарах тооцоолол судалгаа хийсэн.<br>2.И-Монгол Академи УТҮГ-ын шинжээч нартай хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж, захиалагчийн шаардлага, процессын зураглалыг тайлбарын хамт хүргүүлсэн.<br>3.Апп-р тээврийн хэрэгслийг бүртгүүлэхэд:<br>-Иргэн регистрийн дугаараар хүсэлтээ илгээхэд 5 минут; | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Хур системээс мэдээлэл харуулахад 1 мин буюу нийт 6 минут зарцуулдаг болно.<br>4.Дээрх програмыг улсын төсвөөс зардал гаргахгүйгээр төлбөргүй хийлгэсэн бөгөөд 2024.12.15-ны өдрөөс туршилтаар нэвтрүүлнэ. | | |
| 17 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Цахим нэг цонхны мэдээллийн системийг бий болгох ажлын хэсэгт ажиллаж, холбогдох мэдээллийг хүргүүлнэ. | ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023.08.10-ны өдрийн А/138 дугаартай тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт гаалийн байгууллагын төлөөлөл ажиллаж байна. "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийг хэрэгжүүлэгч байгууллага өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгасан хугацааг шинэчилж, үйл ажиллагаа нь зохион байгуулагдана. "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийн нэгжээс "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системд оролцогч 19 байгууллагын 40 албан хаагчийг оролцуулсан 2024.03.21, 2024.03.25, 2024.06.20-ны өдөр зохион байгуулагдсан уулзалтуудад оролцсон.<br>Монгол улсад гадаад худалдааны харилцааг зохицуулах тарифын бус хязгаарлалтын аргаас бүртгэл, зөвшөөрлийн хэлбэрийг хамгийн өргөн хэрэглэдэг бөгөөд улсын хилээр нэвтрүүлэх тодорхой нэрийн бараанд тусгай зөвшөөрөл болон бүртгэл олгох замаар төрөөс хяналт тавьж байна. Иймд гадаад худалдаатай холбоотой дээрх зөвшөөрлийг олгодог байгууллагууд цахим нэг цонх мэдээллийн системийг ашиглаж, олон төрлийн үйлчилгээ, мэдээллийг нэг дор төвлөрүүлсэнээр гаалийн байгууллагын үйл ажиллагааг хялбарчилж, гадаад худалдаанд оролцогч нарт чирэгдэлгүй орчин бүрдүүлэхийг зорьж ажиллаж байна.<br>-"Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 178 дугаар тогтоолын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг 2023.06.02-ны өдөр ГЕГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дээрх төлөвлөгөөний 2024 оны 1, 3, хагас жилд хэрэгжүүлэхээр тусгагдсан 14 арга хэмжээний биелэлтийг ГЕГ-ын 8 нэгжээс дотоод зурвасаар авч, нэгтгэн 2024 оны 4, 7, 10 дугаар саруудад ө 01/1638, 2769, 4114 дугаартай албан бичгийн хавсралтаар ЭЗХЯ-ны ТНБД-д хүргүүлсэн. | 01.02<br>12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Засгийн газрын Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2023 оны 178 дугаар тогтоолын<br>1.1."Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээг ЦХХХЯ-тай хамтран хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд ЭЗХ-ийн сайд, Хөрөнгө оруулалт, худалдааны газар, ГЕГ-т даалгасаны дагуу дээрх тогтоолын 1.1, 1.4, 3.1-р заалтын биелэлтийг сар бүр тогтмол гаргаж, ГЕГ-ын ХХ-т хүргүүлэн ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин:<br>1.ГЕГ-ын даргаар 2023.06.02-ны өдөр батлуулсан төлөвлөгөөний 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан 14 арга хэмжээний биелэлтийг ГЕГ-ын 8 нэгжээс дотоод зурвасаар авч, нэгтгэн 2024 оны 4, 7, 10 дугаар саруудад 01/1638, 2769, 4114 дугаартай албан бичгийн хавсралтаар ЭЗХЯ-ны ТНБД-д хүргүүлсэн.<br>2.СЯ-д сар бүр хүргүүлэх Засгийн газрын 178 дугаар тогтоолын 1.1, 1.4, 3.1 дүгээр заалтын биелэлтийг сар бүр тогтмол гаргаж, дараа сарын 01-ний өдрийн дотор ГЕГ-ын Хуулийн хэлтэст хүргүүлж ажилласан.<br>3.Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан CEPS, CAIS системд нэмэлт хөгжүүлэлт хийж, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын мэдүүлгийг E-mongolia болон эмийн бүртгэл, мэдээллийн Licemed системээс цахимаар татаж, гаалийн бүрдүүлэлт хийдэг болгосон.<br>4.Онцгой албан татвартай барааны хяналтыг сайжруулах зорилгоор тусгай зөвшөөрөл, онцгой албан татварын тэмдэгтэй холбоотой мэдээллийг ХХААХҮЯ, Татварын Ерөнхий газартай солилцох системын хөгжүүлэлтийг хийж байна. Үүний үр дүнд гадаад худалдаанд оролцогч нар согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын мэдүүлгийг цаасаар гаалийн байгууллагад гаргаж өгөх шаардлагагүй болж, бүрдүүлэх бичиг баримтын тоо багасна.<br>5.Озон задалдаг, дэлхийн дулаарлд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан, ашигласан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрлийг цахимжуулан, CAIS-т холбож, мэдээлэл солилцох системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд БОУАӨЯ-ны ОУА-тай хамтран ажиллаж байна. | | |
| 18 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Хөрш орны гаалийн байгууллагатай хилийн хяналтын | 1.Монгол Улс, БНХАУ-ын гаалийн байгууллагын 2024 оны хилийн хамтарсан шалгалтын уулзалтыг БНХАУ-ын ГЕГ-аас зохион байгуулах ээлжтэй болович, өнөөдрийн байдлаар | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бусад чиг үүргийн хэрэгжилт. | | | үйл ажиллагааг уялдуулах зорилгоор хамтарсан шалгалт, холбоо баригч дарга нарын уулзалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангана. | уулзалтын товтой холбоотой мэдээлэл ирүүлээгүй байна. Хилийн хамтарсан шалгалтын ажлын хэсгийн 10-р хуралдааныг 2023.09.07-ны өдөр цахимаар амжилттай зохион байгуулж, 4 асуудлаар Протоколд гарын үсэг зурсан. Өнөөдрийн байдлаар Протоколын Монголын талын хэрэгжилт 94.2, Протоколыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээтэй төлөвлөгөөний биелэлт 86.6 хувьтай байна. БНХАУ-ын ГЕГ-аас 2024 оны хамтарсан шалгалтын уулзалтын бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2024.06.05-ны өдөр и майлээр "Хяналт, шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх" төслийг ирүүлсэн. Иймд дээрх төсөлтэй танилцаж саналаа 2024.06.10-ны өдрийн 231 дугаартай дотоод зурвасаар БНХАУ-ын ГЕГ-т хүргүүлэхээр ГХАХ-т хүргүүлэн хариу хүлээж байна.<br>2.Монгол Улс, БНХАУ-ын хилийн гаалийн байгууллагын холбоо баригч дарга нарын 2023 оны хуралдаан 2023.10.30,31-ний өдрүүдэд Замын-Үүд суманд зохион байгуулагдаж, 9 асуудлаар санал солилцож Протоколд гарын үсэг зурсан. Өнөөдрийн байдлаар Протоколын Монголын талын хэрэгжилт 95, Протоколыг хэрэгжүүлэх 13 арга хэмжээний биелэлт 98.1 хувьтай байна. Хөх хотын гаалийн байгууллагын дарга өөрчлөгдсөн тул 2024 оны уулзалтыг хойшлууллаа гэсэн мэдээллийг холбоо баригчаар дамжуулан ирүүлсэн.<br>3.Монгол Улсын ХБГ болон ОХУ-ын ХГА-ны Сибирийн гаалийн газар, Алс Дорнодын гаалийн газар хоорондын хилийн холбоо баригч дарга нарын 2023 оны уулзалтыг 2023.07.20, 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж, талууд 9 асуудлаар санал солилцож, Протоколд гарын үсэг зурсан. Өнөөдрийн байдлаар протоколын Монголын талын хэрэгжилт 95, Протоколыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээний биелэлт 98.8 хувьтай байна. ОХУ-ын ХГА-аас 2024.04.19-ний өдөр "Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын рентген тоног төхөөрөмж ашиглан мэдээлэл солилцох тухай хэлэлцээр"-ийг шинэчлэх төсөл ирүүлсэн. Иймд төсөлтэй танилцаж боловсруулсан саналаа дэд даргаар хянуулж, ОХУ-ын ХГА-д уламжлуулахаар 2024.06.12-ны өдрийн 238 дугаартай дотоод зурвасаар ГХАХ-т хүргүүлсэн.<br>Хүрсэн үр дүн:<br>1.Монгол Улс, БНХАУ-ын гаалийн байгууллагын 2023 оны хилийн хамтарсан шалгалтын ажлын хэсгийн 9-р хуралдааны Протоколын Монголын талын хэрэгжилт 94.2, Протоколыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээтэй төлөвлөгөөний биелэлт 86.6 хувьтай байна.<br>2.Монгол Улс, БНХАУ-ын хилийн гаалийн байгууллагын холбоо баригч дарга нарын 2023 оны хуралдааны Протоколын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монголын талын хэрэгжилт 95, Протоколыг хэрэгжүүлэх 13 арга хэмжээний биелэлт 98.1 хувьтай байна.<br>3.Монгол Улсын ХБГ болон ОХУ-ын ХГА-ны Сибирийн гаалийн газар, Алс Дорнодын гаалийн газар хоорондын хилийн холбоо баригч дарга нарын 2023 оны уулзалтын Протоколын Монголын талын хэрэгжилт 95, Протоколыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээний биелэлт 98.8 хувьтай байна.<br>4.ОХУ-ын ХГА-аас 2024.04.19-ний өдөр ирүүлсэн "Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын рентген тоног төхөөрөмж ашиглан мэдээлэл солилцох тухай хэлэлцээр"-ийг шинэчлэх төсөлтэй танилцаж, саналаа 2024.06.12-ны өдрийн 238 дугаартай дотоод зурвасаар ГХАХ-т хүргүүлж, ОХУ-ын ХГА-д уламжлуулсан.<br>5.БНХАУ, ОХУ-тай хил залгаа орших боомтод хяналт тавьж ажилладаг гаалийн байгууллагууд болон талуудын холбоо баригч нараар дамжуулан мэдээллийг тухай бүр солилцож ажилласан. Хятадтай хил залгаа боомтуудаар 2023 оны эхний 11 сард 551658 тээврийн хэрэгслээр экспортын эрдэс бүтээгдэхүүн тээвэрлэж байсан бол 2024 оны эхний 11 сард 646668 тээврийн хэрэгслээр экспортын эрдэс бүтээгдэхүүн тээвэрлэж, тээвэрлэлт 17.2 хувиар нэмэгдсэн.<br>6.ОХУ-тай хиллэдэг авто замын боомтоор 2023 оны 11 дүгээр сарын байдлаар суудлын 250783, ачааны 56373 тээврийн хэрэгсэл хилээр нэвтэрсэн бол 2024 оны 11 дүгээр сарын байдлаар суудлын 270438, ачааны 61225 тээврийн хэрэгсэл тус тус хилээр нэвтэрсэн. Үүнээс харахад ОХУ-тай хиллэдэг боомтуудаар нэвтрэх суудлын тээврийн хэрэгслийн тоо 7.8 хувиар, ачааны тээврийн хэрэгслийн тоо 8.6 хувиар нэмэгдсэн.<br>7.БНХАУ-ын ГЕГ-аас 2024.06.05-ны өдөр и майлээр ирүүлсэн "Хяналт, шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх" төсөлтэй танилцаж саналаа 2024.06.10-ны өдрийн 231 дугаартай дотоод зурвасаар ГХАХ-т хүргүүлэн БНХАУ-ын ГЕГ-т уламжлуулсан. | | |
| 19 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ОУАТХ-ны программ хангамжийн багтай цахимаар холбогдож 2 талын хугацаа нь дууссан эрхийг нээлгэнэ.<br>IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо (НАРТАМ) - | Олон Улсын автотээврийн холбооны програм хангамжийн багтай Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг уялдуулж, холбох ажлыг 2021 оны 9 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлсэн. IRU-ийн зөвлөх Вахтанг Зарандиятай 2024.05.22-ны өдөр харилцан санал солилцож, тохиролцсоны дагуу 2024.10.24-ний өдрөөс эхлэн IRU-тай TIR-EPD-ийн 6 элементийг туршиж, дараа нь CAIS-т нарийн үйлдлүүдийг хийсэн.<br>ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзоригоор ахлуулсан ажлын хэсэг 2024.11.10 - | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох программыг турших, нэвтрүүлнэ. | 2024.11.15-ны өдрүүдэд Алтанбулаг, Замын-Үүд боомтод томилолтоор ажиллаж CAIS-т ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбох туршилтыг хийж, амжилттай нэвтрүүлсэн. Дээрх ажилтай холбоотойгоор МТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг 2024.11.11-ний өдөр CAIS-т TIR-ын урьдчилсан цахим мэдүүлгийн систем TIR-EPD-ийг бүртгэх сургалтыг ЗҮГГ-т зохион байгуулж, ЗҮГГ-ын 15 албан хаагчийг танхимаар, УБГГ, СЭГГ, БӨГГ, ХОГГ, ДАГГ-ын 98 албан хаагчийг цахимаар оролцуулсан.<br>Мөн ГЕГ-ын дэргэдэх МТГ-аас нийт ГУБ нарт зориулан "ТИР карней бүхий бараа тээврийн хэрэгслийг CAIS системд бүртгэх, хяналт тавих гарын авлага" боловсруулан CERP-д байршуулсан.<br>ГЕГ-ын дарга Р.Отгонжаргал Олон улсын автотээврийн холбооны ТИР болон дамжин өнгөрөх тээврийн хэлтсийн ахлах зөвлөх Вахтанг Зарандиятай 2024.11.18-ны өдөр ГЕГ-ын 1 дүгээр давхарын хурлын танхимд уулзаж, CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн ажлын явцыг дүгнэсэн.<br>ГЕГ-ын даргын 2024.11.19-ний өдөр баталсан удирдамжийн дагуу ХБГ, ОНХА-ын албан хаагч нар Замын-Үүд боомтод 2024.11.20-ны өдрөөс 23-ны өдрүүдэд ажиллаж дуустал 4 хоногийн хугацаатай ажиллаж Олон улсын автотээврийн холбооны ТИР болон дамжин өнгөрөх тээврийн хэлтсийн ахлах зөвлөх Вахтанг Зарандия, МАТНХ-ны гүйцэтгэх захирал Д.Наранпүрэв нарт Замын-Үүд боомтын ачааны терминалд ТИР, транзит тээвэрлэлтийг нэвтрүүлэх замын эгнээ, гаалийн байгууллагын бүртгэл, хяналтыг танилцуулж, ТИР-ын самбарыг байршуулахтай холбоотой асуудлаар санал солилцсон.<br>Цаашид Замын-Үүдээс бусад боомтоор ТИР карней бүхий бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн мэдээг CAIS-т хүлээн авах хугацааг тодруулах, ойлголтын зөрүүг арилгах зорилгоор ГЕГ-ын ХБГ, ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын албан хаагч нар IRU-ын програм хангамжийн багийнхантай хамтарч ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин:<br>1.Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд 2024.11.24-ний өдөр ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн.<br>2.CAIS-т TIR-ын урьдчилсан цахим мэдүүлгийн систем TIR-EPD-ийг бүртгэх сургалтыг 2024.11.11-ний өдөр ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын албан хаагч нартай хамтран ЗҮГГ-т зохион байгуулж, ЗҮГГ-ын 15 албан хаагчийг танхимаар, УБГГ, СЭГГ, БӨГГ, ХОГГ, ДАГГ-ын 98 албан хаагчийг цахимаар оролцуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4.IRU-ийн ТИР болон транзит хариуцсан ахлах зөвлөх Вахтанг Зарандиятай хамтран TIR-EPD холболтын гүйцэтгэлийн үнэлгээ, CAIS дахь ТИР карней статусыг шалгах, EGIS шалгалтыг хэрхэн хийсэн тухай, EPD028/EPD016 мессежийг автоматжуулахтай холбоотой техникийн асуудлуудыг хамтран хянасан.<br>5.БНХАУ-ын ГЕГ-ын ХШГ-ын дарга Жанг Тао-д 2024.12.02-ны өдрийн 02-1/4999 дугаартай албан бичгээр Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн тухай мэдээллийг хүргүүлсэн.<br>5.Замын-Үүдээс бусад боомтоор ТИР карней бүхий бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн мэдээг CAIS-т хүлээн авах хугацааг тодруулах, ойлголтын зөрүүг арилгах зорилгоор ГЕГ-ын ХБГ, ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын албан хаагч нарыг IRU-ын програм хангамжийн багийнхантай уулзаж, хамтарч ажиллах боломжийг цаг алдалгүй зохион байгуулахтай холбоотой саналаа 2024.12.02-ны өдрийн 02-1/5010 дугаартай албан бичгээр НАРТАМ-д хүргүүлсэн. | | |

Хоёр. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2023.03.09-ний өдрийн А/37-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | Гаалийн хяналт шалгалтын “Ухаалаг гарц” иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах ажлын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ажлын хэсэгт ажилласан. | 01.02<br>11.30 | 100 |
| 2 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2023.03.09-ний өдрийн А/38-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | Гаалийн хяналт шалгалтын “Рентген” иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах ажлын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ажлын хэсэгт ажилласан. | 01.02<br>11.30 | 100 |
| 3 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2023.03.09-ний А/39 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | Гаалийн хяналт шалгалтын “Дээж авагч” иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах ажлын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ажлын хэсэгт ажилласан. | 01.02<br>11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын А/369-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | Бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн ажлын хэсэгт ажилласан. | 01.02 11.30 | 100 |
| 5 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ХХААХҮЯ-ын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | "Монгол-Хятадын ЭКСПО" арга хэмжээг зохион байгуулах дэд ажлын хэсэгт ажилласан. | 01.02 11.30 | 100 |
| 6 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | БСҮХ-ны 2023.08.11-ний өдрийн А/41 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | Замын-Үүд боомтын цагийн горимд өөрчлөлт оруулах, боомтын бэлэн байдлыг хангаж, бэлтгэл ажлыг эхлүүлэх ажлын хэсэгт ажилласан. | 01.02 11.30 | 100 |
| 7 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | МУ-ын ЕС-ын 2023.08.18-ны 136 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | Тавантолгойн нүүрсний ордын олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсэгт ажилласан. | 01.02 11.30 | 100 |
| 8 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЭЗХС-ын 2023.09.08-ны А/59-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 233 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хэсэгт ажилласан. | 01.02 11.30 | 100 |
| 9 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023.11.01-ний өдрийн А/215 дугаартай тушаал | Алтанбулаг чөлөөт бүсэд импортоор худалдаалагдаж байгаа архи, согтууруулах ундааны худалдаанд хийсэн хязгаарлалттай холбоотой асуудлыг судлах, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. | 01.02 11.30 | 100 |
| 10 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.02.27-ны өдрийн А/124 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | ГЕГ-ын даргын 2024.02.27-ны өдрийн А/124 тушаалаар байгуулагдсан ДГБ-ын ХХХ-ийн хэрэгжилтийг хангах, ХХ үндэсний хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэгт ажилласан. | 02.27 12.10 | 100 |
| 11 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЭЗХС-ын 2024.03.29-ний өдрийн А/14 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | ЭЗХС-ын 2024.03.29-ний өдрийн А/14 тушаалаар байгуулагдсан АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд хийгдэх хилийн байгууллагуудын хяналт удирдлагын нэгдсэн систем хөгжүүлэлтийн ажлын уялдааг хангах ажлын хэсэгт Б.Даваасүрэн ажиллаж байна. | 03.29 12.10 | 100 |
| 12 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.06.06-ны өдрийн А/339 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах. | Гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хангуулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах, зөвлөмж чиглэлээр хангах, дүн шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах үүрэг бүхий ГЕГ-ын даргын 2024.06.06-ны өдрийн А/339 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт Б.Даваасүрэн ажиллаж байна. | 06.06 12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Уулзалт хэлэлцүүлэгт оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Шуудангийн шинэчлэл" сэдвээр зохион байгуулсан уулзалтад оролцох | ЦХИХХЯ-аас 2024.09.17-ны өдөр "Шуудангийн шинэчлэл" сэдвээр зохион байгуулсан уулзалтад ХБГ-ын ГУБ Д.Ням-Осор, Н.Ойнбилэг нарын хамт оролцсон. | 09.17<br>09.17 | 100 |
| 14 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | БСҮХ-ны даргын 2024.09.12-ны өдрийн А66 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороонд ажиллах | БСҮХ-ны даргын 2024.09.12-ны өдрийн А66 тушаалаар байгуулагдсан АХБ-ны зээлээр хэрэгжүүлэх Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл Б-14, Ухаалаг гарц Б-16 гаалийн хяналтын зорилгоор ашиглах суурин тоног төх.сонгон шалгаруулах Үнэлгээний хороонд ажиллаж байна. | 09.12<br>11.30 | 100 |
| 15 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.10.09-ний өдрийн А548 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | ГЕГ-ын даргын 2024.10.09-ний өдрийн А548 дугаартай тушаалаар байгуулагдсан Гаалийн байгууллагын 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулж, батлуулах ажлын хэсэгт ажилласан. | 10.09<br>11.30 | 100 |
| 16 | Зочны цаг нэвтрүүлэгт оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | С1 ТВ-ийн зочны цагт оролцож мэдээлэл өгөх. | С1 ТВ-ийн зочны цагт уригдан гаалийн байгууллагын хяналтын тоног төхөөрөмжийн шинэчлэл сэдвээр 2024.10.30-ны өдрийн 14:00 цагаас шууд ярилцлага өгсөн. | 10.30<br>10.30 | 100 |
| 17 | Уулзалтад оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | БНТУ-ын ЭСЯ-аас 2024.11.11-ний өдөр зохион байгуулсан уулзалтад оролцох | БНТУ-ын ЭСЯ-аас 2024.11.11-ний өдөр зохион байгуулсан "Өрнө дорнын найрамдал болон торгоны зам 2025 авторалли" -ийн бэлтгэл ажлыг хангах уулзалтад оролцсон. | 11.11<br>11.11 | 100 |
| 18 | Уулзалтад оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГХЯ-ны Зөвшилцөл танхимд зохион байгуулагдах уулзалтад оролцох | НҮБ-ын АНДЭЗНК-ын Зүүн болон Зүүн Өмнөд Азийн салбартай хамтран ЗТЯ-ны Далайн захиргаанаас 2024.11.13-ны 14:00-18:00 цагт ГХЯ-ны Зөвшилцөл танхимд зохион байгуулсан уулзалтад ГЕГ-ын дэд даргын хамт оролцсон. | 11.13<br>11.13 | 100 |
| 19 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | АҮЭБ-ийн Сайдын 2024.11.19-ний өдрийн А/40 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | АҮЭБ-ийн Сайдын 2024.11.19-ний өдрийн А/40 дугаартай тушаалаар байгуулагдсан 1995 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2023.07.07-ны өдрийн 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Дэд ажлын хэсэгт ажиллаж байна. | 11.19<br>11.30 | 100 |
| 20 | Томилолтоор ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.11.19-ны өдөр баталсан удирдамжийн дагуу томилолтоор ажиллах | ГЕГ-ын даргын 2024.11.19-ны өдөр баталсан удирдамжийн дагуу CAIS-т TIR-EPD-г холбож, нэвтрүүлсэнтэй холбогдуулан Эрээний гаалийн байгууллагын удирдлагуудтйа уулзалт зохион байгуулах ажлаар Замын-Үүд гаалийн газарт томилолтоор ажилласан. | 11.20<br>11.23 | 100 |

Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | | | Үр дүнгийн үзүүлэлт | | |
|---|---|---|---|---|---|

| | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Төрийн албан тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Танхим, цахимаар суралцсан байна. | 2024 онд Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах ажлын хүрээнд дараах сургалтад хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн.Үүнд:<br>-2024.03.07-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн "Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийг танилцуулах "7:4:10" цахим сургалт,<br>-2024.04.25-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" сэдвийн хүрээнд явагдах "7:4:10" цахим сургалт,<br>-2024.10.17-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн "Нийгмийн даатгалын эрх зүйн орчны шинэтгэл, хуулийн хэрэглээ" сэдвийн хүрээнд "7:4:10" цахим сургалт. | 02.20<br>12.10 | 90 |
| 2. | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Танхимаар суралцсан байна. | -Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024.01.12-ны өдрийн хуулиар Гаалийн тухай хуульд оруулсан нэмэлтүүдтэй танилцсан.<br>ГЕГ-ын даргын 2019 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан "Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Чөлөөт бүсийн тухай хууль, Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенцийг судалсан.<br>-"Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах журам"-ын төсөл боловсруулахтай холбогдуулан:<br>-Өрсөлдөөний тухай хууль;<br>-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;<br>-Сангийн сайдын 2019 оны 306 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журам";<br>-ЗТХ-ийн сайдын 2023 оны А/48 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг зохион байгуулах журам"; | 01.02<br>12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -ЗГ-ын 2016 оны 10 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг тус тус судалсан. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДАВААСҮРЭН / 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

# ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДАВААСҮРЭНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хяналт, бүрдүүлэлтийн газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 63,14 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан дунд хугацааны сургалтад хамрагдах | | 12 |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, заавар тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | | 12 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 12 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 13 |
| 2 | Удирдан зохион байгуулах | 8 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 7,5 |
| 4 | Манлайлах | 8 |
| 5 | Багаар ажиллах | 7,5 |
| 6 | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар | – |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 9,83 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 63,14 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний | 12 |

| | | |
|---|---|---|
| | биелэлт | |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 9,83 |
| **Нийт оноо=**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 85 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч**

Гаалийн ерөнхий газрын дарга ............................ (Р.Отгонжаргал)

2024.12.19.......... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................ (Б.Даваасүрэн)

2024.12.20.......... (огноо)